



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 8

- Монгол Улсад 1997 онд оруулж болох цагаач иргэдийн тоо, бүтэц болон байршлын тухай Монгол Улсын хууль
- Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль
- Авилгалын эсрэг хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Хэвлэл

№ 1997 оны 8-р сар №5 /63/

## ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1. Монгол Улсад 1997 онд оруулж болох цагаач иргэдийн тоо, бүтэц болон байршлын тухай	663
2. Хүн амын орлогын албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай	663
3. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	664
4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай	669
5. Гэрээ соёрхон батлах тухай	669
6. Хэтэлцээр соёрхон батлах тухай	670
7. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд өөрчлөлт оруулах тухай	670
8. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	671
9. Ажилгалийн жэрэг хуульд нэмэлт оруулах тухай	675

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

0. Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр нөхөн томилгох тухай №49	676
1. Ерөнхийлөгчийн хоригийн тухай №50	676
2. 1997 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай №52	677
3. Нөхөн сонгууль зарлан явуулах тухай №53	678
4. Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай №54	679
5. Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг сунгах тухай №55	679
6. Төрөлжсөн хуудийн төсөл боловсруулах тухай №56	680
7. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өмчийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай №57	680
8. Пунсалмаагийн Очирбатын хангамж, хамгаалалтын тухай №58	681
9. Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөмжлөл бий болгох тухай №59	682
10. Хуулийн төсөл буцаах тухай №60	683
11. Хуулийн төсөл буцаах тухай №61	684
12. Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай №62	684

23. Санал хураах комисс байгуулах тухай №63	688
24. Байнгын хороодын дарга нарыг сонгох тухай №64	689
25. Өрийг чөлөөлөх эрх олгох тухай №65	689
26. Төрийн өндөр албан тушаалтны хэрэг, дэнд хамаарах болон түүнтэй адилтгах албан тушаалын шалонгийн тухай №66	691
27. Нутгийн өөрийн удирдлагын дэд хорооны бүрэлдэхүүний тухай №67	691
28. Үндэсний статистикийн газрын даргыг томилох тухай №68	692
29. Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай №69	692
30. Намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай №70	693

### 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

31. Я.Жадамбаад Монгол Улсын Гавьяат барилгачин цол олгох тухай №04	697
32. Б.Нэргүйд Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол олгох тухай №05	697
33. Б.Алтангэрэлд Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгох тухай №06	698
34. Т.Оюутад Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгох тухай №07	698
35. Зарим хүнийг одонгоор шагнах тухай №08	699

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ

36. Монгол Улсын Их Хурлын дарга Р.Гончигдорж Үндсэн хуулийн зарим заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай №01	700
37. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай №01	705

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

38. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг тайлбарлах тухай №237	709
--	-----

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

39. Зарим тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай №135	710
40. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай №136	710
41. Нутгийн захиргааны талаар авах зарим арга хэмжээний тухай №137	711
42. Байгаль орчны намны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус намны бүтцийг батлах тухай №140	713
43. Батлан хамгаалах намны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус намны бүтцийг батлах тухай №141	731
44. Гэгээрлийн намны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус намны бүтцийг батлах тухай №142	745
45. Дүрэм батлах тухай №144	759
46. Автомашин гүрээслүүлэх журмыг батлах тухай №148	765
47. Зарим тогтоол, тогтоолын заалт хүчингүй болсонд тооцох тухай №149	768
48. Хууль зүйн намны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус намны бүтцийг батлах тухай №151	770

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 4 дүгээр  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСАД 1997 ОНД ОРУУЛЖ БОЛОХ ЦАГААЧ ИРГЭДИЙН ТОО, БҮТЭЦ БОЛОН БАЙРШЛЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсад 1997 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоог 90-ээс дээшгүй байхаар тогтоосутай.

**2 дугаар зүйл.** Монгол Улсад 1997 онд оруулж болох цагаач иргэдийн бүтцийг дор дурдсанаар тогтоосутай:

1/Оросын Холбооны Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;

2/Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харьяат иргэн 30-аас дээшгүй;

3/бусад орны харьяат иргэн 30-аас дээшгүй.

**3 дугаар зүйл.** Монгол Улсад 1997 онд оруулж болох цагаач иргэдийн байршлыг дор дурдсанаар тогтоосутай:

1/ Улаанбаатар хотод 40-өөс дээшгүй;

2/ Дархан-Уул, Орхон, Дорнод, Сэлэнгэ, Архангай аймаг тус бүрд 1-ээс дээшгүй;

3/ бусад аймагт 5-аас дээшгүй.

4/ гэр бүлээрээ ирсэн цагаач иргэдийг хамт байршуулах үүднээс энэ зүйлийн 1, 2, 3-г заасан хязгаарлалтыг хамааруулахгүй байж болно.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүн амын орлогын албан татварын хуудийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "а"-гийн "40 хувиар" гэснийг "10 хувиар" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Хүн амын орлогын албан татварын хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "а", "б"-гийн "нөхөн олговор, хөнгөлөлтийн орлого /унаа, түлш, хоол, байрны үнийн хөнгөлөлт гэх мэт/" гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

#### ОРЛОГЫГ НЬ ТУХАЙ БҮР ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУВИАРАА ЭРХЛЭГЧ ИРГЭНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ, хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй дараахь ажил, үйлчилгээ эрхлэгч иргэнд сар тутам дор дурдсан хэмжээгээр албан татвар ногдуулна:

Ажил, үйлчилгээний төрөл	Албан татварын хэмжээ /төгрөгөөр/			
	Улаан-баатар хотод	Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумдад	Бусад аймгийн төвийн сумдад	Бусад газарт
А	1	2	3	4
1. Хот, сумын дотор автомашинаар зорчигч тээврийн үйлчилгээ хийх: 1/ 4 хүртэл хүний суудалтай автомашинаар 2/ 8 хүртэл хүний	6000	5500	3500	2500

суудалтай автомашинаар	7500	6500	6000	4500
3/ 15 хүртэл хүний суудалтай автомашинаар	10500	9500	8000	6000
4/ автобусаар	12000	11000	8000	6000
<b>2.Хот, сум, аймгийн хооронд зорчигч тээврийн үйлчилгээ хийх:</b>				
1/ 4 хүртэл хүний суудалтай автомашинаар	9000	7000	5000	4000
2/ 8 хүртэл хүний суудалтай автомашинаар	11000	9000	7000	5000
3/15 хүртэл хүний суудалтай автомашинаар	13000	11000	9000	7000
4/ автобусаар	15000	13000	11000	9000
<b>3.Хот, сумын дотор ачаа тээврийн үйлчилгээ хийх:</b>				
1/ 1 хүртэл тоннын даацтай автомашинаар	12000	10000	8000	6000
2/1-3тн-ын даацтай--	14000	12000	10000	8000
3/3-5тн-ын даацтай--	16000	14000	12000	10000
4/5-8тн-ын даацтай--	18000	16000	14000	12000
5/8-аас дээш тн-ын даацтай --	20000	18000	6000	15000
6/трактораар	8000	6000	4000	2000
<b>4.Хот, сум, аймгийн хооронд ачаа, тээврийн үйлчилгээ хийх:</b>				
1/1 хүртэл тн-ын даацтай автомашинаар	14000	12000	10000	8000
2/1-3тн-ын даацтай--	16000	14000	12000	10000
3/3-5тн-ын даацтай--	18000	16000	14000	12000
4/5-8тн-ын даацтай--	20000	18000	16000	14000
5/8-аас дээш тн-ын даацтай --	22000	20000	18000	16000
6/трактораар	10000	8000	6000	4000

5. Уран зураг, баримал, сийлбэр, бэлэг дурсгалын зүйл хийж худалдах	2400	2000	1600	1000
6. Бэлэг дурсгал, гоёлын зүйл, төрөл бүрийн тоглоом хийх	3000	2000	1000	500
7. Алт, мөнгөний дархны үйлчилгээ хийх	16000	14000	12000	10000
8. Бэлэг дурсгалын зүйлд дурсгалын үг бичих, засал хийх	2400	2000	1000	200
9. Чимэглэлийн болон тасалгааны ургамал, цэцэг тарьж худалдах	1200	900	600	200
10. Автомашин болон тээврийн бусад хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх	18000	16000	14000	12000
11. Радио, телевиз засварлах	6000	4000	2000	1000
12. Гэр ахуйн зориулалттай техник, багаж хэрэгсэл, эд хогшил засварлах	4500	3500	2500	1500
13. Цаг засварлах	3000	2000	1000	500
14. Барилгын засал чимэглэл, засвар, үйлчилгээ хийх	8000	6000	4000	2000
15. Багшлах, давтлага өгөх, дасгалжуулах	2000	1600	1200	1000
16. Бичгийн машинаар эх бэлтгэх	2400	2000	1600	300
17. Үсчин, гоо сайхны үйлчилгээ үзүүлэх	6000	4000	2000	1000
18. Ардын болон уламжлалт эмнэлгийн бариа засал хийх	6000	4000	2000	1000
19. Эмнэлгийн бусад үйлчилгээ	6000	4000	2000	1000
20. Байгалийн баялаг цуглуулж худалдах	2400	1800	1200	600

21. Гэрэл зургийн үйлчилгээ хийх	8000	6000	4000	2000
22. Захиалгаар кино зураг авах, дүрс бичлэг хийх	7000	6000	3000	1000
23. Видео киноны хальс төлбөргүйгээр ашиглуулах	8000	6000	4000	1000
24. Дууны бичлэг бүхий хальс төлбөргүйгээр ашиглуулах	2400	2000	1600	1000
25. Видео кино үзүүлэх	6000	4000	2000	1000
26. Төлбөрг тоглоом тоглуулах	12000	9000	4500	3000
27. Худалдаа хийх	6000	4000	2000	1000
28. Жижиг худалдаа /тамхи, бохь гэх мэт/ хийх	2400	2000	1600	600
29. Төрөл бүрийн хүнсний зүйл үйлдвэрлэж худалдах	6000	4000	2000	1000
30. Гутал засварлах	3200	2800	2400	2000
31. Гутал төслөх	900	400	200	100
32. Ачаа тээш боох, ачиж буулгах, хүргэх үйлчилгээ хийх	2800	2000	1200	-
33. Ердийн хөсгөөр үйлчилгээ хийх	5000	3000	1500	1000
34. Малын арьс шир, ноос, ноолуур болон бусад түүхий эдийг зуучлан цуглуулж худалдах	8000	6000	4000	2000
35. Савхин болон бусад эдлэл будах	4000	2000	1000	500
36. Валютын худалдаа хийх	25000	15000	10000	5000
37. Видео, аудио бичлэг хуулж худалдах	10000	6000	4000	1000
38. Мэрэг төлөг үзэх	1200	1000	800	400



**2 дугаар зүйл.** Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийн 3 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсгийн дугаарыг 3, 4, 5 болгон өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

"2. Улс хооронд зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ хийх тухай бүрд дор дурдсан хэмжээгээр албан татвар ногдуулна:

Ажил үйлчилгээний төрөл	Албан татварын хэмжээ /төгрөгөөр/	
	Замын-Үүд, Алтан-булаг боомтоор	Бусад боомтоор
<b>1. Улс хооронд зорчигч тээврийн үйлчилгээ хийх тухай бүрд:</b>		
1/ 4 хүртэл хүний суудалтай автомашинаар	10000	6000
2/ 8 хүртэл хүний суудалтай "-	12000	8000
3/ 16 хүртэл хүний суудалтай "-	14000	10000
4/ автобусаар	18000	12000
<b>2. Улс хооронд ачаа тээвэрлэх үйлчилгээ хийх тухай бүрд:</b>		
1/ 1-3 тн-ын даацтай автомашинаар	16000	10000
2/ 3-5 тн-ын даацтай "-	18000	12000
3/ 5-8 тн-ын даацтай "-	20000	14000
4/ 8-аас дээш тн-ын даацтай "-	22000	16000
5/ трактораар	10000	4000

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 1997 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ  
ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Статистикийн тухай Монгол Улсын хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуудан 1994 оны 3 дугаар сарын 17-ны өдөр баталсан Статистикийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Статистикийн тухай Монгол Улсын хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 1996 оны 9 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн Нью-Йорк хотноо гарын үсэг зурахад нээлттэй болсон "Цөмийн уршилтыг бүрэн хориглох Гэрээ"-г Монгол Улсын Засгийн газрын эргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөрУлаанбаатар  
хот

## ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1997 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Эрчим хүчний хэмнэлтийн төслийг хэрэгжүүлэх талаар Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан зээлийн Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөрУлаанбаатар  
хотАВТО ТЭЭВРИЙН БОЛОН ӨӨРӨӨ ЯВАГЧ  
ХЭРЭГСЛИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 4, 5, 6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчилсүгэй:

Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн төрөл	Жилд ногдуулах албан татвар /төгрөгөөр/	
	Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон аймгийн төвийн сумд	Бусад бүх сумд
А	1	2
~3.Суудлын автомашин:	/Цилиндрийн багтаамжийн нэг см <sup>3</sup> тутамд төгрөгөөр/	
а/2000 см <sup>3</sup> хүртэл	16	14
б/2001-3000 см <sup>3</sup> хүртэл	18	16
в/3001 см <sup>3</sup> -аас дээш	22	20

4.Микро автобус /15 хүртэл суудлын/	35000	28000
5.Автобус	52000	40000
6.Ачааны автомашин:		
1/ 1 хүртэл тн-ын даацтай	25000	20000
2/ 1-2 тн-ын даацтай	35000	28000
3/ 2-3 тн-ын даацтай	45000	36000
4/ 3-5 тн-ын даацтай	55000	44000
5/ 5-8 тн-ын даацтай	80000	64000
6/ 8-10 тн-ын даацтай	90000	72000
7/ 10 тн-оос дээш даацтай	100000	80000

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1997 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор зурасанаар өөрчлөн найруулсугай.

1/ 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Улсын Их Хурал Байнгын хороог үйл ажиллагааныхаа талбар, чиглэлээр байгуулах бөгөөд дараахь Байнгын хороодтой байна:

1. Аюулгүй байдал, галаад бодлогын;
2. Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн;
3. Нийгмийн бодлогын;
4. Төрийн байгуулалтын;
5. Төсвийн;
6. Хууль зүйн;
7. Эдийн засгийн.

2/ 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Байнгын хороо дараахь эрхлэх асуудлын хүрээнд бүрэн эрхээ эргэжүүднэ:

**1/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:**

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;
- Монгол Улсын аюулгүй байдлыг хангах бодлого;
- Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;
- Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;
- Монгол Улсын хил, түүний хамгаалалт;
- гадаад бодлого;
- гадаадад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилж асуудал;
- Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улс олон улсын байгууллагад элсэх тухай асуудал.

**2/ Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хороо:**

- газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал, агаар мандал болон байгалийн бусад баялаг;
- ашигт малтмал, газрын тосны нөөц, эрэл хайгуул, судалгаа;
- улсын тусгай хамгаалалттай газар, бэлчээр, тариалангийн газар;
- геологи, уул уурхай байгаль орчны төрийн хяналт;
- агаарын бохирдол, хорт бодис байгаль орчны асуудал;
- усны бодлого, нөөц, усны бохирдол;
- хог хаягдал, дахин боловсруулалт;
- байгаль орчны бодлого;
- байгаль орчны судалгаа, хөгжил;
- ан агнуур;
- газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, хангамж;
- хүнсний хяналт, аюулгүй байдал;
- үрийн аж ахуй;
- мал аж ахуйн бодлого;
- мал, мах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хяналт;
- малын өвчин;
- малын даатгал.

**3/ Нийгмийн бодлогын байнгын хороо:**

- боловсрол;
- соёл урлаг;
- шинжлэх ухаан, технологийн хөгжил;
- ард түмний түүх, соёл, оюуны өвийг сэргээх, хамгаалж талаархи бодлого;
- монгол хэл, бичиг, үндэстний цөөнхийн хэл, бичиг, соёл урлаг;
- ёс заншлын талаар төрөөс баримтлах бодлого;
- хүн амын бодлого;
- хүн амын эрүүл мэнд;
- хөдөөгийн нийгмийн бодлого;

- нийгмийн хамгаалал;
- нийтийн биеийн тамир, спорт;
- хөдөлмөр эрхлэлт;
- хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалал.

#### 4/ Төрийн байгуулалтын байнгын хороо:

- төрийн эрх барих дээд болон гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн байгуулалт;
- Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль;
- Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, хилийн цэс;
- төрийн алба;
- төрийн бэлгэ тэмдэг, төрийн дуулал;
- ард нийтийн санал асуулга;
- төр, сүм хийдийн харилцаа;
- хэвлэл, мэдээллийн хэрэгслэл;
- улс төрийн нам, төрийн байгууллага;
- Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал;
- Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;
- Улсын Их Хурлын гишүүний хөдөлмөр, ахуйн асуудал;
- Улсын Их Хурал, нам, эвслийн бүлгийн болон Улсын Их Хурлын гишүүний төсвийн хяналт;
- Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг;
- Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн биелэлт.

#### 5/ Төсвийн байнгын хороо:

- улсын төсөв, төсвийн орлого, зарлага;
- төсвийн нэмтгэл, гүйцэтгэл, хяналт;
- төрийн санхүү, зээл, албан татварын бодлого;
- төрийн зээлийн хэлцэл;
- Улсын Их Хурлын төсөв.

#### 6/ Хууль зүйн байнгын хороо:

- Монгол Улсын эрх зүйн бодлого;
- Хүний эрх, эрх чөлөө, түүний баталгаа, гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх бодлого;
- хэвлэл, мэдээллийн эрх чөлөө;
- хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэс, ялын бодлого;
- шүүх, прокурор, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага;
- нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн үндэс;
- эрүү, иргэн, захиргааны байцаан шийтгэх ажиллагаа;
- өршөөл үзүүлэх асуудал;
- патент, зохиогчийн эрх, худалдааны тэмдгийн асуудал;
- цагаачлал, иргэний харьяатын асуудал;

- архив;
- эрх зүйн сурталчилгаа;
- эрх зүйн туслалцаа;
- өмгөөллийн асуудал;
- үл хөдлөх хөрөнгийн бүртгэл.

**7/ Эдийн засгийн байнгын хороо:**

- Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл;
- эдийн засгийн дотоод, гадаад бодлого;
- банк, Монголбанкны үйл ажиллагаа;
- эдийн засгийн тогтвортой байдал;
- төрийн өмчийн асуудал;
- гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжийн асуудал;
- дэд бүтцийн асуудал;
- газар, газрын тосны асуудал, байгалийн баялаг, ашигт малтмал;
- шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах, худалдааг хамгаалах асуудал;
- төрөөс аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлого;
- эрчим хүчний бодлого;
- хэмжил зүй, стандартчилал, чанарын баталгаажуулалт;
- статистик;
- стандартчилал хэмжил зүйн асуудал;
- барилга, хот байгуулалт, хотын хөгжил;
- аялал, жуулчлал.

**2 дугаар зүйл.** Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг**

"1. Улсын Их Хурал зохих Байнгын хороонд харьяалагдах доо дурдсан дэд хороотой байна:

- 1/ Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороонд:  
Тусгай хяналтын;
- 2/ Төрийн байгуулалтын байнгын хороонд:  
а/ Ёс зүйн;  
б/ нутгийн өөрийн удирдлагын.
- 3/ Төсвийн байнгын хороонд:  
Төсвийн зарлагын хяналтын.
- 4/ Хууль зүйн байнгын хороонд:  
Хүний эрхийн."

**2/ 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

"4. Дэд хороод дараахь асуудлыг эрхэлнэ:

- 1/ Тусгай хяналтын дэд хороо:
  - Монгол Улсын аюулгүй байдал;
  - Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт.

2/Ес зүйн дэд хороо:

- Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал;
- Улсын Их Хурлын гишүүний ёс зүй;
- Улсын Их Хурлын чуулганы дэгийн биелэлт;
- Улсын Их Хурлын гишүүний орлогын мэдүүлэг.

3/Нутгийн өөрийн удирдлагын дэд хороо:

- нутгийн өөрөө удирдах ёс;
- нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөвшил, хөгжил;
- нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн байдал.

4/Төсвийн зарлагын хяналтын дэд хороо:

- төсвийн орлого, зарлага;
- төсвийн хяналт.

5/Хүний эрхийн дэд хороо:

- хүний эрх, эрх чөлөөний баталгаа;
- өршөөл үзүүлэх асуудал;
- цагаачлал, иргэний харьяаллын асуудал.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1997 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1997 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Улаанбаатар  
хот

### АВИЛГАЛЫН ЭСРЭГ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авилгалын эсрэг хуулийн 8 дугаар зүйлд дор үрдсэн агуулгатай 3 дахь хэсэг нэмсүгэй:

“3.Хөрөнгө, орлогын мэдүүлэгт тухайн албан тушаалтан өөрийн мчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгөө үл хөдлөх эд хөрөнгийн үртгэлийн байгууллагад бүртгүүлсэн албан ёсны тодорхойлолтыг ивэсргана.”

**МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 6 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

**Төрийн хянан шалгах хорооны  
гишүүнээр нөхөн томилгох тухай**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Лувсандандарын Хангайг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр нөхөн томилсугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 6 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

**Ерөнхийлөгчийн хоригийн тухай**

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

"Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5, 6 дахь заалтад Монгол Улсын Ерөнхийлөгчөөс тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
хот

**1997 оны улсын төвлөрсөн төсвийн тухай  
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай  
хуулийг хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай**

Монгол Улсын 1997 оны төвлөрсөн төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Улсын төвлөрсөн төсвийн алдагдлыг багасгах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1996 оны 67 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцын талаар намрын чуулганд тайлагнахыг Засгийн газар, Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

2. 1991-1996 онд гадаадаас авсан зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, эх үүсвэрийн төвлөрүүлэлтийн байдалд шалгалт хийж, 1997 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Төрийн хянан шалгах хороонд даалгасугай.

3. Монголбанк, Засгийн газрын хооронд үүссэн өр, авлагыг нягтлан тооцоо нийлж, холбогдох арга хэмжээ авч энэ тухайгаа Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газар, Монголбанкнд даалгасугай.

4. Түлш, эрчим хүчний салбар дахь өрийн сүлжээг арилгах асуудлыг судалж, санал боловсруулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулахыг Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

5. Засгийн газарт /М.Энхсайхан/-т даалгах нь:

1/ төсвийн ангиллыг олон улсын ангилалд нийцүүлэх, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, төсвийн орлого, зарлагыг нэр төрөл, зүйлээр нь батлах чиглэлээр Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж өргөн мэдүүлэх,

2/ төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр олгосон зээлийн хөрөнгийн ашиглалт, зээлийн өрийн барэгдуулалтын талаар 1997 оны 10 дугаар сард багтаан Улсын Их Хуралд мэдээлэх,

3/ нийт төсөвт байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, түүнд тавих хяналтыг боловсронгуй болгох талаар тодорхой санал, хуулийн төслийг Улсын Их Хурлын намрын чуулганд оруулах,

4/ цэрэгжсэн байгууллагуудын тоог цөөрүүлэх, цэрэг, цагдаагаас бусад байгууллагад хувцасны зардал олгохоор холбогдох хуулиудад заасныг хянан үзэж, төсвөөс санхүүжүүлдэг тусгай хувцасны зардлыг бууруулах чиглэлээр санал боловсруулах;

5/ Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалтын объектын жагсаалтыг нарийвчлан хянаж, шинэчлэн тодотгох;

6/ Сангийн яам, Монголбанк хамтран экспортын даатгалын сан, хөгжлийн банк байгуулж гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрийг төвлөрүүлэн зарцуулах асуудлыг судлах;

7/ соёлын болон бусад салбарын тусгай зориулалттай сангуудын бүтцийг хянан үзэж хөрөнгийн зориулалтыг оновчтой, үр ашигтай болгож, санхүүжилтийн аргыг боловсронгуй болгох;

8/ төсөвт байгууллагуудын сонинг төсвөөс санхүүжүүлж байгааг зогсоох;

9/ элсэн чихрийн үйлдвэрийг угсарч, ашиглалтад оруулахад шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх

6 Өнчин, тэнэмэл хүүхдийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран төсөл боловсруулж, Засгийн газрын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэх эрхийг Засгийн газарт олгосугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 53

Улаанбаатар  
хот

#### Нөхөн сонгууль зарлан явуулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Улсын Их Хурлын Сонгуулийн хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 21 дүгээр тойрог дахь нөхөн сонгуулийг 1997 оны 7 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэхээр зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 21 дүгээр тойрогт нөхөн сонгуулийн санал хураалтыг 1997 оны 8 дугаар сарын 17-ны өдөр явуулахаар тогтоосугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 54

Улаанбаатар  
хот

**Нөхөн сонгуулийн зардлын  
хэмжээ тогтоох тухай**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 21 дүгээр тойрогт явуулах нөхөн сонгуульд улсын төвлөрсөн төсвөөс зарцуулах зардлын хэмжээг 2 961 900 төгрөг байхаар тогтоосугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 55

Улаанбаатар  
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны  
бүрэлдэхүүний бүрэн эрхийн  
хугацааг сунгах тухай**

Монгол Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны бүрэн эрхийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ нь:**

Сонгуулийн ерөнхий хорооны бүрэлдэхүүний бүрэн эрхийг 1998 ны 1 дүгээр сарын 1 хүртэлх хугацаанд сунгасугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 56

Улаанбаатар  
хот

Төрөлжсөн хуулийн төсөл  
боловсруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нийгмийн даатгал, нийгмийн халамжийн асуудлын эрх зүйн үндсийг боловсронгуй болгох зорилгоор Нийгмийн даатгал болон Нийгмийн халамжийн талаархи хуулиудыг нэгтгэн төрөлжсөн нэг хууль /кодекс/-ийн төслийг шинэчлэн найруулах хэлбэрээр боловсруулж 1998 оны 1 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 57

Улаанбаатар  
хот

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн  
осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр,  
тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

I. Дор дурдсан арга хэмжээг 1997 оны 9 дүгээр сарын 1-ний дотор багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай:

1/1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тогтоогдсон тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэврийг "Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай" хуулийн дагуу Засгийн газрын 1997 оны 73 дугаар тогтоолоор баталсан "Үнэ, тариф, амьжиргааны өртгийн өөрчлөлт, тэтгэвэр бодох цалин, хөдөлмөрийн хөлсний хоорондын зохистой харьцаа"-г баримтлан тэдний 1995

оноос өмнөх цалин, хөдөлмөрийн хөлсний дунджаар тооцон шинэчлэн тогтоох;

2/1995 оноос өмнө үйлдвэртэл, ажлын осол, гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисст оруулан хөдөлмөрийн чадвар алдалтыг нь магадлан тогтоолгох арга хэмжээг зохион байгуулах.

2.Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 1-д заасныг баримтлан тогтоосон тэтгэвэр болон 1995 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөрийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгож байсугай.

3.Энэ тогтоолын 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу шинэчлэн тогтоосны улмаас тухайн иргэний өмнөх тэтгэврийн хэмжээ буурахад хүрвэл өмнө тогтоогдсон тэтгэврийг нь олгож байсугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 58

Улаанбаатар  
хот

**Пунсалмаагийн Очирбатын хангамж,  
хамгаалалтын тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай:

1/Монгол Улсын анхны Ерөнхийлөгч байсан П.Очирбатын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон өдрөөс эхлэн дөрвөн жилийн хугацаанд өвлийн орон сууцлар хангаж, түүний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх;

2/ 50 хавтгай дөрвөлжин метр ашигтай талбай бүхий хувийн орон сууцны байшинтай болгох арга хэмжээ авах;

3/ хуульд заасан бусад хангамж, хамгаалалт болон энэ тогтоолыг биелүүлэх арга хэмжээ авах.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 59

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөмжлөл бий болгох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч байсныг хүндэтгэсэн хүндэтгэл болох Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөмжлөлийг бий болгосугай.

2. Энэхүү өргөмжлөлийг Монгол Улсын Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалтад дурдснаар тангарагаасаа няцаж, бүрэн эрхээ зөрчин огцорсноос бусад тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч байсан хүнд Улсын Их Хурлаас олгож байхаар тогтоосугай.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөмжлөлийн үг нь "Төрийн их хэргийг төвшитгөж, түмэн олноо амгалан болгохуй үйлсэд бие сэтгэлээ чилээж, билиг авьяасаа зориулсныг тань хөхүүлэн сайшааж, энэхүү өргөмжлөлийг барив." гэсэн нийтлэг агуулгатай байна.

4. Өргөмжлөлийн загварыг Улсын Их Хурлаас тухай бүрт нь батална.

5. Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийн өргөмжлөлийн загварыг хавсралт ёсоор баталсугай.

6. Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийн өргөмжлөлийг бий болгохтой холбогдон гарах зардлыг төсвийн зохих хэсгээс зарцуулахыг Засгийн газар /М.Энхсайхан/-т даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1997  
оны 59 дүгээр тогтоолын хавсралт

### МОНГОЛ УЛСЫН АНХНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ӨРГӨМЖЛӨЛИЙН ЗАГВАР

1. Монгол Улсын анхны Ерөнхийлөгчийн өргөмжлөл нь Өнө мөнхөд үүрд бат оршихын бэлгэдэл болсон түмэн наст хээгээр

хүрээлж, дээд талд төрийн алтан соёмбоо залж, доод талд хиргүй ариун цагааны бэлгэдэл бадма цэцгийг товойлгосон байх юм.

Өргөмжлөлийн үгийг мөнгөлсөн гадаргуу дээр эзэн Чингисийн үеэс улсын бичиг байсан монгол бичгээрээ бичиж, алтадсан байна.

2.Өргөмжлөлийн үг нь:

"Монгол Улсын анхны Ерөнхийлөгч  
Пунсалмаагийн Очирбат Та,

Төрийн их хэргийг төвшингөж, түмэн олноо амгалан болгохуй  
үйлсэд бие сэтгэлээ чилээж, билэг авьяасаа зориулсныг тань  
хөхүүлэн сайшааж, энэхүү Өргөмжлөлийг барив.

*Монгол Улсын Их Хурал*

Арвандолдугаар жарны гал үхэр жилийн  
зуны дунд сарын арван таван." гэсэн байна.

3.Өргөмжлөлийн их биеийн нийт хэмжээ нь 40 х 25 см, зузаан нь 1 см, хээний өргөн нь 3,3 см, соёмбоны өндөр нь 8,3, бадма цэцгийн өндөр 4,9 см байна. Өргөмжлөлийн соёмбо, хээ, үсэг, бадма цэцгийг 3-4 мм товойлгосон байна.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 3-ны өдөр

Дугаар 60

Улаанбаатар  
хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Улсын Их Хурлын гишүүн Шаравжамцын Батбаяраас 1997 оны 6 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн "Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай" хуулийн төслийг нийгмийн цаатгал, нийгмийн халамжийн хуулиудтай хэрхэн уялдах, шаардагдах зөрөнгө мөнгөний тооцоог нягтлах, Засгийн газрын санал авах ёлон амьжиргааны доод түвшинг үнэ, тарифын өөрчлөлттэй холбох зэрэг асуудлаар төслийн зарим зүйл, заалтыг тодотгох шаардлагатай гэж үзэж уг төслийг хууль санаачлагчид буцаасугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 61

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Засгийн газраас 1997 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Иргэний хуульд нэмэлт оруулах тухай хууль"-ийн төслийг Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцүүлэх нь зүйтэй гэж үзэж уг төслийг хууль санаачлагчид буцаасугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 62

Улаанбаатар  
хот

### *Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны бүрэлдэхүүний тухай*

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Монгол Улсын Их Хурлын Байнгын хороодыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1/Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:

1. Ендонпунцагийн Адилбиш
2. Бат-Эрдэнийн Батбаяр
3. Эрдэнийн Бат-Үүл
4. Сангажавын Баярцогт
5. Ажханы Болат
6. Лувсанвандангийн Болд
7. Жамсрангийн Бямбадорж
8. Раднаасүмбэрэлийн Гончигдорж

9. Очирбатын Дашбалбар
10. Данзанхорлоогийн Дашпүрэв
11. Санжаасүрэнгийн Зориг
12. Данзангийн Лүндээжанцан
13. Ринчингийн Нарангэрэл
14. Үнэнбүрэнгийн Наранцэцэг
15. Цэндийн Нямдорж
16. Таукейн Султан
17. Сорогжоогийн Төмөр
18. Санжбэгзийн Төмөр-Очир
19. Цэвээндоржийн Төмөртогтоо
20. Нямаагийн Түвшинтөгс
21. Цэрэнхүүгийн Шарандорж
22. Дамдинсүрэнгийн Энхбаатар
23. Ойдовын Энхтуяа
24. Цахиагийн Элбэгдорж
25. Төмөр-Очирын Эрдэнэбилэг

2/ Байгаль орчин, хэлээний хөгжлийн  
байнгын хороо:

1. Рагчаагийн Бадамдамдин
2. Батжаргалын Батбаяр
3. Шаравжамцын Батбаяр
4. Даржаагийн Батнасан
5. Намдагийн Батцэрэг
6. Цэвэлмаагийн Баярсайхан
7. Надмидын Баярсайхан
8. Данзангийн Бохышарга
9. Цэрэндоржийн Ганхуяг
10. Жамбын Гомбожав
11. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
12. Хэнмэдхэвийн Даштэвэг
13. Жамбын Норовсамбуу
14. Жамъянгийн Отгонбаяр
15. Донногийн Цогт-Очир
16. Должингийн Цогбадрах

3/ Нийгмийн бодлогын байнгын хороо:

1. Норовын Алтанхуяг
2. Шаравжамцын Батбаяр
3. Шийлэгийн Батбаяр
4. Даржаагийн Батнасан
5. Жамсрангийн Бямбадорж
6. Адъяагийн Ганбаатар
7. Төгсжаргалын Ганди

8. Раднаасүмбэрэлийн Гончигдорж
9. Данзанхорлоогийн Дашпүрэв
10. Самбуугийн Ламбаа
11. Ринчингийн Нарангэрэл
12. Чүлтэмийн Отгонбаяр
13. Таукейн Султан
14. Санжбэгзийн Төмөр-Очир
15. Чүлтэмийн Улаан
16. Норжмоогийн Тогтох
17. Хашбатын Хулан
18. Долгорын Хувьтөгөлдөр
19. Должингийн Цогбадрах

#### 4/Төрийн байгуулалтын байнгын хороо

1. Ёндонпунцагийн Адилбиш
2. Намдагийн Батцэрэг
3. Дашжамцын Баттулга
4. Эрдэнийн Бат-Үүл
5. Сангажавын Баярцогт
6. Саригийн Батчулуун
7. Ажханы Болат
8. Данзангийн Бохьшарга
9. Төгсжаргалын Ганди
10. Галсанпунцагийн Ганхуяг
11. Жамбын Гомбожлв
12. Очирбатын Дашбалбар
13. Хэнмэдхэвийн Дашзэвэг
14. Пунцагийн Жасрай
15. Мэндийн Зэнээ
16. Данзангийн Лүндээжанцан
17. Цэндийн Нямдорж
18. Сорогжоогийн Төмөр
19. Жемьенгийн Отгонбаяр
20. Чимэдийн Сайханбилэг
21. Раздакийн Сандалхан
22. Хашбатын Хулан
23. Мишигийн Чимэдцэрэн
24. Цэрэнхүүгийн Шаравдорж
25. Данзанбалжирын Энхтайван
26. Цагаандарийн Энхтүвшин

#### 5/Төсвийн байнгын хороо:

1. Ринчиннямын Амаржаргал
2. Аюурзаны Базархүү
3. Дашжамцын Баттулга

4. Соёлсүрэнгийн Билэгсайхан
5. Сэрээтэрийн Болдхэт
6. Агъяагийн Ганбалтар
7. Даваадоржийн Ганболд
8. Догсомын Ганболд
9. Цэрэндоржийн Ганхуяг
10. Сандагийн Гончиг
11. Дамдингийн Дэмбэрэл
12. Рэнчинсамбуугийн Одонбаатар
13. Түвдэнгийн Очирхүү
14. Рэнцэнгийн Содхүү
15. Санжбэгзийн Төмөр-Очир
16. Нямаагийн Түвшинтөгс
17. Данзанбалжирын Энхтайван
18. Ямааранзын Эрхэмбаяр

6/ Хууль зүйн байнгын хороо:

1. Саригийн Батчулуун
2. Батжаргалын Батбаяр
3. Соёлсүрэнгийн Билэгсайхан
4. Банзрагчийн Дэлгэрмаа
5. Мэндийн Зэнээ
6. Луузангийн Лувсан-Очир
7. Чүлтэмийн Отгонбаяр
8. Чимэдийн Сайханбилэг
9. Долгорын Хувьтөгөлдөр
10. Цахиагийн Элбэгдорж
11. Дамдинсүрэнгийн Энхбаатар
12. Ойдовын Энхтуяа
13. Төмөр-Очирын Эрдэнэбилэг

7/ Эдийн засгийн байнгын хороо:

1. Норовын Алтанхуяг
2. Ринчиннямын Амаржаргал
3. Рагчаагийн Бадамдамдин
4. Аюурзанын Базархүү
5. Шийлэгийн Батбаяр
6. Цэвэлмаагийн Баярсайхан
7. Надмидын Баяртсайхан
8. Лувсанвандангийн Болд
9. Сэрээтэрийн Болдхэт
10. Даваадоржийн Ганболд
11. Догсомын Ганболд
12. Галсанпунцагийн Ганхуяг
13. Сандагийн Гончиг

14. Ёндон-Ойдовын Гэрэлчулуун
15. Дамдингийн Дэмбэрэл
16. Пунцагийн Жасрай
17. Самбуугийн Ламбаа
18. Луузангийн Лувсан-Очир
19. Үнэнбүрэнгийн Наранцэцэг
20. Жамбын Норовсамбуу
21. Түвшэнгийн Очирхүү
22. Ралдакийн Сандалхан
23. Рэнцэнгийн Содхүү
24. Норжмоогийн Тогтох
25. Цэвээндоржийн Төмөртоогоо
26. Чүлтэмийн Улаан
27. Дониогийн Цогт-Очир
28. Мишигийн Чимэдшэрэн
29. Цагаандарийн Энхтүвшин
30. Ямааранзын Эрхэмбаяр

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тогтоолыг 1997 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 63

Улаанбаатар  
хот

Санал хураах комисс байгуулах  
тухай

Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын Байнгын хороодын даргыг сонгох санал хураалтыг зохион байгуулж, дүнг илтгэх үүрэг бүхий санал хураах комиссыг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1. Н.Алтанхуяг
2. Д.Батнасан

3. Ши.Батбаяр
4. Л.Лувсан-Очир
5. Р.Содхүү

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 64

Улаанбаатар  
хот

**Байнгын хороодын дарга нарыг  
сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 12 дугаар зүйл, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Санжаасүрэнгийн Зориг; Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны даргаар Цэвэлмаагийн Баярсайхан; Нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар Хашбатын Хулан; Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Дашжамцын Баттулга; Төсвийн байнгын хорооны даргаар Адьяагийн Ганбаатар; Хууль зүйн байнгын хорооны даргаар Чүлтэмийн Отгонбаяр; Эдийн засгийн байнгын хорооны даргаар Даваадоржийн Ганболд нарыг тус тус сонгосугай.

2. Энэ тогтоолыг 1997 оны 7 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 65

Улаанбаатар  
хот

**Өрийг чөлөөлөх эрх олгох тухай**

Хүнсний үйлдвэр, комбинатуудад 1991-1993 онд үүссэн онцгой албан татварын өрийг өнөөгийн нөхцөлд бүрэн төлүүлэх боломжгүй зайгааг харгалзан тэдгээр үйлдвэр, комбинатуудын санхүүгийн

төлбөрийн чадварыг сайжруулан үйлдвэрлэлээ өргөтгөх хөрөнгө оруулах нөхцөлийг бий болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хүнсний үйлдвэр, комбинатуудын /хавсралтад заасан/ онцгой албан татварын өрийн 30 хувийг тэдгээр үйлдвэр, комбинат 1997 оны 9 дүгээр сард багтаан төлсөн нөхцөлд өрийн үлдэх 70 хувийг хүчингүй болсонд тооцох шийдвэр гаргах эрхийг Монгол Улсын Засгийн газарт олгосугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

Улсын Их Хурлын 1997 оны 7 дугаар сарын  
9-ний өдрийн 65 тоот тогтоолын хавсралт

**ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР, КОМБИНАТУУДЫН  
ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ӨР**

Үйлдвэр, комбинатын нэр	Онцгой татварын өр /мян.төг/
1.Архангай "Хүнс Архангай"	5473.3
2.Баянхонгор "Хүнсний үйлдвэр"	58048.1
3.Булган "Шим" ХК	7887.3
4.Булган "Олз" ХК	18610.0
5.Говь-Алтай "Тулга-Алтай" ХК	23512.0
6.Дорнод "Дорнод хүнс" ХК	91482.1
7.Дундговь "Говийн тэнгэр" ХК	41752.2
8.Завхан "Баялаг" ХК	13005.1
9.Өвөрхангай "Шимтлэг" ХК	41108.3
10.Өвөрхангай "Дэлгэрэх хүнс" ХК	37163.4
11.Өмнөговь "Хүнсний үйлдвэр"	9149.4
12.Сүхбаатар "Билгэх баянбүрд"	1595.2
13.Сэлэнгэ "Сэлэнгэ шим" ХК	514.5
14.Төв "Хүнс Төв" ХК	5572.0
15.Увс "Увс хүнс" ХК	25007.6
16.Ховд "Алтайн Буян" ХК	30461.3
17.Хөвсгөл "Хөвсгөл хүнс" ХК	35300.0
18.Хэнтий "Хангал" ХК	467.0
19.Улаанбаатар "АПУ" ХК	211551.0
20."Эрдэнэт хүнс" ХК	76366.5
Нийт дүн	734026.3

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар  
хот

**Төрийн өндөр албан тушаалтны зэрэг,  
дэвд хамаарах болон түүнтэй адилтгах  
албан тушаалын цалингийн тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. "Төрийн улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн болон албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1995 оны 65 дугаар тогтоолын 1, 2, 3, 4 дүгээр хэсэг, "Цалингийн хэмжээ тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 1995 оны 67 дугаар тогтоол, "Нутгийн өөрөө удирдах байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Их Хурлын 1997 оны 1 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийн дагуу тус тус тогтоосон албан тушаалын цалингийн хэмжээг 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 20 хувиар нэмэгдүүлсүгэй.

2. Төрийн улс төрийн албан тушаалын цалингийн шинэчилсэн бодлогыг боловсруулж Улсын Их Хуралд оруулж хэлэлцүүлэхийг Засгийн газар /М.Энхсайхан/-т үүрэг болгосугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 67

Улаанбаатар  
хот

**Нутгийн өөрийн удирдлагын дэд хорооны  
бүрэлдэхүүний тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны сарьяанд Нутгийн өөрийн удирдлагын дэд хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1.Ёндонпунцагийн Адилбиш

-Улсын Их Хурлын гишүүн



2. Ажханы Болат	-Улсын Их Хурлын гишүүн
3. Намдагийн Батцэрэг	-Улсын Их Хурлын гишүүн
4. Данзангийн Бохьшарга	-Улсын Их Хурлын гишүүн
5. Сангажавын Баярцогт	-Улсын Их Хурлын гишүүн
6. Галсанпунцагийн Ганхуяг	-Улсын Их Хурлын гишүүн
7. Хэнмэдхэвийн Дашзэвэг	-Улсын Их Хурлын гишүүн
8. Жамьянгийн Отгонбаяр	-Улсын Их Хурлын гишүүн
9. Сорогжоогийн Төмөр	-Улсын Их Хурлын гишүүн
10. Данзанбалжирын Энхтайван	-Улсын Их Хурлын гишүүн
11. Цагаандарийн Энхтүвшин	-Улсын Их Хурлын гишүүн

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

Үндэсний статистикийн газрын  
даргыг томилж тухай

Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг  
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Чүлтэмжамцын Даваасүрэнг Үндэсний статистикийн газрын  
даргаар томилсугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар 69

Улаанбаатар  
хот

Зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай

Статистикийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг  
үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Үндэсний статистикийн газрын зөвлөлийг дараахь бүрэлдэхүүн  
тэйгээр байгуулсугай:

- 1/Монголбанкны Статистик, судалгааны газрын захирал;
- 2/Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга;
- 3/Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Стратегийн удирдлагын эрын дарга;
- 4/Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны референт

**ДАРГА****Р.ГОНЧИГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1997 оны 7 дугаар  
сарын 9-ний өдөр

Дугаар70

Улаанбаатар  
хот

### Намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 1997 оны намрын ээлжит улганаар дараахь асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай:

**Нэг. Нийгмийн хамгааллын асуудалтай холбоотой хуулийн төслүүд:**

- 1/Хүн амын амьжиргааны доод түвшингийн тухай хуулийн төсөл
- 2/Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн төсөл
- 3/Хөдөлмөрийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- 4/Эрүүл мэндийн тухай хуулийн төсөл
- 5/Долоо хоногийн ажлын цагийг ажлын 5 өдөрт шилжүүлэх тухай хуулийн төсөл

**Хоёр.Эдийн засаг, санхүү, аж ахуйн үйл ажиллагаатай  
холбоотой хуулийн төслүүд болон бусад асуудал:**

- 6/ Орон сууцны тухай ерөнхий хуулийн төсөл
- 7/Иргэний хувийн өмчийн газрын тухай хуулийн төсөл
- 8/Газар хувьчлах тухай хуулийн төсөл
- 9/Хоршооны тухай хуулийн төсөл
- 10/Шударга бус өрсөлдөөнийг хязгаарлах тухай хуулийн төсөл
- 11/Монгол Улсын 1998 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн төсөл
- 12/Төрөөс мөнгөний бодлогын талаар 1998 онд баримтлах чиглэл

- 13/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 1998 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
- 14/Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцын тухай
- 15/Улсын төсвийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- 16/Нийгмийн салбарын хувьчлалын тухай хуулийн төсөл
- 17/Газрын бүртгэлийн зураглалын тухай хуулийн төсөл
- 18/Нэмүү өртгийн татварын тухай хуулийн төсөл
- 19/Төсвийн байгууллагын менежмент, санхүүжилтын тухай хуулийн төсөл
- 20/ а.Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал  
б.Монгол Улсын хүн амын нутагшлын байршил, хөгжлийн ерөнхий төсөл
- 21/Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл
- 22/Дампуурлын тухай хуулийн төсөл
- 23/Арилжааны даатгалын ерөнхий хуулийн төсөл
- 24/Барилгын тухай хуулийн төсөл
- 25/Хот байгуулалтын тухай хуулийн төсөл

**Гурав.Монгол Улсын Үндсэн хуульд хуулиар тусгайлан зохицуулахаар заасан хуулиуд:**

- 26/Дайн бүхий байдлын тухай хуулийн төсөл
- 27/Гадаадын цэргийн хүнийг байрлуулах, дамжуулан өнгөрүүлэх тухай хуулийн төсөл
- 28/Яамдын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

**Дөрөв. Бусад хуулиуд:**

- 29/Улс төрийн талаар хэлмэгдэгсдийг цагаатгах тухай хуулийн төсөл
- 30/Батлан хамгаалах тухай хуулийн төсөл
- 31/Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- 32/Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
- 33/Агентлагийн тухай хуулийн төсөл
- 34/Архивын тухай хуулийн төсөл
- 35/Геодези, зураг зүйн тухай хуулийн төсөл
- 36/Сонгуулийн хуулийн төсөл
- 37/Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр
- 38/ а.Олон түмний мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төсөл  
б.Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл

39/Гэр бүлийн тухай хуулийн төсөл

40/Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл

41/Гүйцэтгэх ажлын тухай хуулийн төсөл

42/Тусгай хамгаалалттай газрын орчны бүсийн тухай хуулийн төсөл

43/Ажлын байр бий болгох үндэсний хөтөлбөр

44/бусад асуудал.

2.Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар М.Энхсайхан/-г даалгасугай:

1/Улсын Их Хурлын 1997 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн Засгийн газрын өргөн мэдүүлэх уулийн төслүүдийг 1997 оны 9 дүгээр сарын 15-ны дотор багтаан ргөн мэдүүлэх;

2/ энэ тогтоолын хавсралтад заасан хуулийн төслүүдээс Засгийн газрын өргөн мэдүүлэх хуулийн төслүүдийг 1997 оны 12 дугаар сарын 1-ний дотор өргөн мэдүүлэх.

3.Намрын чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэлийг сайтар ингахыг Байнгын хороодын дарга нарт даалгасугай.

**ДАРГА**

**Р.ГОНЧИГДОРЖ**

Улсын Их Хурлын 1997 оны  
70 дугаар тогтоолын хавсралт

**УЛСЫН ИХ ХУРЛЫН НАМРЫН ЧУУЛГАНААР  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР САНАЛ БОЛГОСОН ХУУЛЬ,  
ТОГТООЛЫН ТӨСЛҮҮДИЙН ЖАГСААЛТ**

- 1.Эдийн засгийн чөлөөт бүсийн тухай ерөнхий хуулийн төсөл
- 2.Гадаадын зээл, тусламжийг авах, ашиглахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн төсөл
- 3.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт зуулах тухай хуулийн төсөл.
- 4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт, зуулах тухай хуулийн төсөл
- 5.Хөрөнгө оруулалтыг дэмжих, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх рилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах хай хуулийн төслүүд
- 6.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

7.Банкнаас зээлээ төлөөгүйн төлөө хүлээх хариуцлагыг чангатга зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж тухай хуулийн төслүүд

8.Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тухай хуулийн төсөл

9.Нөхөрлөл,компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж тухай хуулийн төсөл

10.Үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

11.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

12. 1998 онд олборлох, Монголбанкинд худалдан авах алтн дээд хэмжээг тогтоох тухай тогтоолын төсөл

13.Аялал жуулчлалын тухай хуулийн төсөл

14.Монгол Улсын төрөөс баримтлах нийгмийн бодлогын үндэс чиглэл

15.1995 оноос өмнө ба хойно тогтоосон тэтгэврийн ялгаг арилгах тухай тогтоолын төсөл

16.Радио долгионы тухай хуулийн төсөл

17.Шуудангийн тухай хуулийн төсөл

18.Автотээврийн тухай хуулийн төсөл

19.Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

20.Авто замын тухай хуулийн төсөл

21.Агаарын зайд нислэг үйлдэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

22.Жижиг дунд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл

23.Худалдааны албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

24.Казиногийн тухай хуулийн төсөл

25.Иргэний хуулийн төсөл

26.Захиргааны хариуцлагын тухай хуулийн төсөл

27.Боловсролын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар  
хот

**Я. Жадамбаад Монгол Улсын Гавьяат  
барилгачин цол олгох тухай**

Барилгын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж нийгэм-ахуйн зориулалттай олон арван барилга байгууламжийг барьж байгуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Улаанбаатар хотын "Нийслэл-Өргөө" холдинг компанийн гүйцэтгэх захирал Янжмаагийн Жадамбаад Монгол Улсын Гавьяат барилгачин цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар  
хот

**Б. Нэргүйд Монгол Улсын Аж үйлдвэрийн  
гавьяат ажилтан цол олгох тухай**

Хүнсний үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж үйлдвэрлэлийн удирдлагыг боловсронгуй болгон, үр ашгийг дээшлүүлж хүн амыг хүнсний бүтээгдэхүүнээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хэнтий аймгийн Гурил тэжээлийн "Буудайн цацал" хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Баянмөнхийн Нэргүйд Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

**Б. Алтангэрэлд Монгол Улсын Хүний  
гавьяат эмч цол олгох тухай**

Төв, орон нутгийн эмнэлгийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, урьдчилан сэргийлэх үзлэг, эмчилгээг тогтмол чанартай хийснээр өвчлөлийг бууруулж хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйл хэрэгт оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Төв аймгийн нэгдсэн эмнэлгийн их эмч Борхүүгийн Алтангэрэлд Монгол Улсын Хүний гавьяат эмч цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1997 оны 7 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар  
хот

**Т. Оюутад Монгол Улсын Соёлын  
гавьяат зүтгэлтэн цол олгох тухай**

Монгол телевизэд олон жил, идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хүүхэд багачууд, өсвөр үеийнхний оюуны эрэлт хэрэгцээнд нийцсэн чамбай бүтээл туурвиж тэднийг сургаж хүмүүжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол телевизийн нэгдсэн редакцийн хариуцлагатай редактор Төгсийн Оюутад Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Н.БАГАБАНДИ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

997 оны 7 дугаар  
арын 7-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар  
хот

Зарим хүнийг одонгоор  
шагнах тухай

Төр, захиргаа, боловсрол, эрүүл мэнд, соёл урлагийн байгууллага, йлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан үмүүсийг одонгоор шагнасугай.

### ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР

- |                      |   |
|----------------------|---|
| Авирмэдийн Цэрэнхүү  | -Нийслэлийн 75 дугаар сургуулийн гэр ахуйн багш, уран хаттамалч |
| Жанчивын Раднаабазар | -Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн дэд захирал               |

### АЛТАН ГАДАС ОДОНГООР

- |                      |   |
|----------------------|---|
| Дэндэвийн Алтангэрэл | -Нийслэлийн 70 дугаар сургуулийн багш                         |
| Бат-Очирын Балжинням | -Төр, засгийн Үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын нягтлан бодогч |
| Нянгарын Бямбасүрэн  | -Ховд аймгийн хөгжимт жүжгийн хүрээлэнгийн гоцлол дуучин      |
| Шекейн Хажнаби       | -Баян-Өлгий аймгийн Нүүрст хотгорын уурхайн экскаваторчин     |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.БАГАБАНДИ



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

1997 оны 2 дугаар  
сарын 5-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Их Хурлын дарга Р.Гончигдорж Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Совд даргалж, гишүүдэд Л.Баасан, Н.Жанцан, С.Жанцан /илтгэгч/, Д.Чилхаажав нарын бүрэлдэхүүнтэй хийв.

Цэцийн хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Цэндээхүүг оролцуулав. Цэцийн хуралдаанд гомдол гаргагч иргэн Ц.Цэрэнжээ, УИХ-ын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Цог, Б.Энэбиш нар оролцлоо.

Нийслэлийн иргэн Ц.Цэрэнжээ: "Монгол телевизээр 1996 оны 12 дугаар сарын 13-ны өдөр, "Ардын эрх" сонины 1996 оны 12 дугаар сарын 14-ний дугаарт УИХ-ын дарга Р.Гончигдоржийн хийсэн мэдэгдлээс үзэхэд тэрээр Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтыг ноцтой зөрчсөн ажиллагаа явуулж байна. Р.Гончигдорж "Ард, Даатгал банкуудыг татан буулгаж, түүний оронд Төрийн өмчийн хадгаламжийн банк, Сэргээн босголтын банк, Өр барагдуулах алба шинээр байгуулагдаж байна... эдгээр банкинд хөрөнгө байршуулсан харилцагч байгууллагууд... алдагдал хүлээх болно" гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төр нь нийгмийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", 3 дахь хэсэгт "Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэжээ. Ард, Монгол даатгал банкууд нь 100 хувь төрийн өмчийн банк биш бөгөөд тухайлбал Ардын банкны дүрмийн сангийн 62,0 хувь нь төрийн бус өмчийнх, олон мянган харилцагч нар хадгаламж эзэмшигчтэй билээ. УИХ-ын дарга банк татан буулгах ажиллагаанд оролцож, түүнийгээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нотолж байгаа нь Үндсэн хуулийн дээр дурьдсан заалтуудыг зөрчиж, банкны хувь нийлүүдэгчид, хөрөнгөө байршуулсан иргэд, хуулийн этгээдүүдийн өмчлөх эрхийг зөрчсөн ажиллагаа явуулан зориудаар алдагдалд оруулж байна.

Дээрхи банкуудын харилцагч нарт хандаж Засгийн газрын байгуулсан банктай харилцахыг тулгаж, цагдаагийн болон Монгол банкны ажилтнууд эдгээр банкны ажилтнуудын өрөөнд нь хууль

ёсны шийдвэргүйгээр орж өрөө, албан өрөө, ширээ, шүүтээг битүүмжилж, утсаар ярих, гадагш гарах, гэртээ харихыг нь хориглосон, ажлаас гарах шаардлага тавих зэрэг ажиллагаа явуулсан байна.

Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт "халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг дээрхи ажиллагаа нь зөрчиж байгаа юм.

УИХ-ын дарга Р.Гончигдорж Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх" заалтыг мөн зөрчиж, одоо хүчин төгөлдөр байгаа хэд хэдэн хуулиудыг зөрчлөө. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бүрэн эрхийнхээ дагуу УИХ-ын даргын үндсэн хууль зөрчиж байгаа ажиллагааг хянан үзэж, хуулийн дагуу зохих шийдвэр гаргахыг хүсье" гэсэн өргөдлийг 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд ирүүлдээ.

Иргэн Ц.Цэрэнжээгийн өргөдөлтэй маргааныг Цэцийн гишүүн Н.Жанцан хянаад "Улсын Их Хурлын дарга Р.Гончигдоржийн радио, телевизээр 1996 оны 12 дугаар сарын 13-нд хийсэн мэдэгдэл нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал биш тул маргаан хянан шалгах ажиллагаа үүсгэхээс татгалзсан 22 дугаар тогтоолыг 1996 оны 12 дугаар сарын 27-ны өдөр гаргасан байна. Иргэн Ц.Цэрэнжээ Цэцийн гишүүн Н.Жанцангийн 22 дугаар тогтоолыг эс зөвшөөрч, Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Совдын нэр дээр өргөдөл ирүүлсэн байна. Ц.Цэрэнжээ өргөдөлдөө: "Миний бие УИХ-ын даргыг Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар өмгөөлөгчийн хувьд бус харин Монгол Улсын иргэний хувьд гомдол гаргасан юм. УИХ-ын даргын радио, телевизээр хэлсэн үгийн дагуу явуулсан ажиллагаатай нь холбогдуулан, түүнчлэн түүний хуулиар өгөгдсөн эрх хэмжээтэй холбогдуулж гаргасан 1996 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 104 тоот захирамжийн зорилго, хүрээ зэргийг хамруулж гомдол гаргасан юм. Цэцийн гишүүний 22 дугаар тогтоолд "Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал биш" гэсэн харилт өгсөн бөгөөд түүнийхээ үндэслэлийг дурьдалгүй орхисон байна. УИХ-ын дарга нь банкуудыг хуулиас гадуур татан буулгах ажиллагааг удирдсан байна. Ард болон Даатгал банкуудыг булаан авах ажиллагаа 1996 оны 12 дугаар сарын 13-ны 15 цагийн орчимд цагдаа, татвар, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны болон Монгол банкны ажилтнуудын хамтын "довтолгоо", хүч хэрэглэсэн байдлаар хэрэгжиж эхэлсэн юм. Дээрхи хоёр банкны ажилтнуудыг үүргээ хэвийн байдлаар гүйцэтгэж байхад гэнэт дайран орж, өрөөнөөс нь хөөн гаргаж, үүд хаалгыг лацдан, түлхүүрүүдийг нь булаан авч "бид нартай ажиллах нь түр гэрээнд гарын үсэг зур,

зурахгүй нь яв" гэх зэргээр загнаж, хууль бус баримтад хүчээр гарын үсэг зуруулжээ. Түүнчлэн банкны ажилтнуудыг гадагш гарах, утсаар ярих, хоолонд орох зэргийг хязгаарлаж, ширээ, шүүгээг нэгжин лацдаж, зарим газар бие засах, хоолонд ороход нь ч цагдаагийн Монгол банкны ажилтнууд харгалзан явж байжээ. Зарим хүмүүсийг ажлаас нь хөөн явуулжээ. Энэ ажиллагаа явагдаж байхад УИХ-ын эрхэм дарга телевизээр үг хэлж, төрийн өмчийн хоёр банк байгуулсан, Ард, Даатгал банкуудыг татан буулгасан, тэдгээр банкинд хөрөнгөө байршуулсан харилцагч байгууллагууд алдагдал хүлээх, 1996 оны 12 дугаар сарын 16-наас Төрийн өмчийн банкууд хэвийн ажиллах тухай мэдэгдэж, дээр дурьдсан хүний эрх, хууль зөрчсөн бузар ажиллагааг зөтгөж хаацайлсан үг хэлсэн билээ.

УИХ-ын дарга Р.Гончигдоржийн гаргасан захирамж, хэлсэн үгийн цаанз чухамхүү Ард болон Даатгал банкуудын эд хөрөнгө, харилцагч, хадгаламж эзэмшигчид, хувь нийлүүдэгчдийн эд хөрөнгө, эрхийг Үндсэн хууль, бусад хуулийг зөрчин төрийн өмчийн Сэргээн босголт, Хадгаламжийн болон бусад банкны мэдэлд булаан авах ажиллагаа байсан юм.

УИХ-ын даргын ажиллагаа нь ямар нэг хуулийн дагуу явагдаагүй бөгөөд харин Үндсэн хууль болон бусад олон хууль зөрчсөн юм. Төрийн эрх барих байгууллагын толгойд байгаа албан тушаалтны Үндсэн хууль зөрчсөн дээрхи ажиллагааг Үндсэн хуулийн цэц зөвтгөн хаацайлах аваас хүний эрх, эрх чөлөө төрийн тэргүүнд гарсан улс төрийн хүчин, хувь хүний хүсэл зорилго, дураар авирлалтын золиос болж, хүн байнга хохирох нь мэдээж билээ.

Иймд Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцангийн 1996 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хянан, иргэн миний гомдлыг дахин авч үзэж, хуульд нийцсэн шийдвэр гаргаж өгөхийг хүсье" гэжээ.

Иргэн Ц.Цэрэнжээгийн энэ гомдлыг 1997 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн гурван гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцээд УИХ-ын дарга Р.Гончигдоржийн үйл ажиллагаа Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай иргэн Ц.Цэрэнжээгийн гомдол нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх асуудал мөн гэж үзээд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний 1996 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хүчингүй болгож, уг гомдлоор маргаан хянан шалгах ажиллагаа үүсгэсэн Үндсэн хуулийн цэцийн 03 тоот магадлал гаргажээ.

Монгол Улсын Их Хурлын Р.Гончигдорж УИХ-ын хуулийн 26 дугаар зүйл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1996 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 14 тоот зөвлөмж, Ерөнхий сайдтай зөвшилцсөнийг үндэслэн Банкны системийн бүтцийн өөрчлөлтийн

хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөх эрх бүхий зөвлөлийг 1996 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн захирамжаараа байгуулсан байна.

УИХ-ын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Цог, Б.Энэбиш нар тайлбартаа "Улсын Их Хурлын даргын захирамж нь хуулийн дагуу түүнд олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд нийцсэн, түүний хэлсэн үг нь үйл явдлыг үнэлж дүгнэсэн, хуулийн заалтын ач холбогдлыг тайлбарлаж ойлгуулахад чиглэгдсэн бөгөөд хууль зөрчөөгүй байна. Төр хууль гаргаж өмчлөгчийн эрх ашгийг мөн хуулиараа хамгаалах учиртай. Харин ч бидний энд маргаж, хэлэлцэж буй дээрх зөвлөл, мэдэгдэл, иргэдийн эрх ашиг хамгаалах үүднээс хийгджээ. Банкны эрх хүлээн авах үед болсон үйл явцад оролцсон, түүнийг зааж зааварласан гэх нотолгоо УИХ-ын даргын захирамжийн хүрээ, агуулга, үг, үсэг, түүний мэдэгдлийн санаанаас огт харагдахгүй байгалийн гадна нэг талаас зөвлөл байгуулсан, мэдэгдэл хийсэн субъект, нөгөө талаас нэр бүхий банкуудыг татан буулгахад иргэний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэх субъект өөр өөр байгаа бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд шалтгаант холбоо үгүй байна. Ард, Даатгал банкуудыг татан буулгахтай холбогдуулж, УИХ-ын дарга Р.Гончигдоржийн хийсэн мэдэгдэл нь Банкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний учир холбогдлыг үнэлж, дүгнэх, мөн хүмүүсийн сонирхож байсан хуулийн заалтын дагуу хийгдэх зарим алхмыг тайлбарласан байна. УИХ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлд УИХ-ын дарга эрх хэмжээнийхээ асуудлаар захирамж гаргах эрхтэй. УИХ-ын дарга нь УИХ-ын бүрэн эрхийг хэрэгжүүлэх ажлыг бүхэлд нь уялдуулан зохицуулах чиг үүрэгтэйг заасан байна.

Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасан "төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлох..." онцгой бүрэн эрхийг хадгалсан УИХ-ын бүрэн эрхээс урган гарч байгаа юм. Энэ бүхнээс дүгнэж үзвэл, Ард, Даатгал банкуудыг татан буулгаж, банкны эрх хүлээн авагчийг томилсонтой холбогдуулж, УИХ-ын дарга Р.Гончигдоржийг Үндсэн хуулийн дээр дурьдагдсан заалтуудыг зөрчсөн гэж үзэх үндэстэл байхгүй байна" гэжээ.

Цэцийн хуралданд оролцсон нэхэмжлэгч иргэн Ц.Цэрэнжээ "УИХ-ын дарга банк татан буулгах ажиллагаанд хутгалдан оролцохын хамт энэ асуудлаар захирамж гаргаж, телевизээр мэдэгдэл хийсэн нь өргөмдл дурьдсанаар Үндсэн хуулийн заалтуудыг зөрчсөн нь эргэлзээгүй. Банк татан буулгах ажиллагаа эртнээс бэлтгэлтэй хийгдсэн нь харагдаж байгаа юм. Иймд Р.Гончигдоржийн үйл ажиллагаа Үндсэн хууль зөрчсөн" гэжээ.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч Л.Цог Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцож, "УИХ-ын дарга Р.Гончигдорж зөвлөл байгуулах захирамж гаргасан, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэл хийсэн нь банкуудыг татан буулгах, шинээр банк байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэнтэй ямар ч шалтгаант холбоогүй учир Үндсэн хууль зөрчөөгүй" гэжээ.

#### Хянавал:

1. Улсын аюулгүй байдлын зөвлөл Банкны системд өөрчлөлт хийхийг зөвлөсөн шийдвэр гаргасны дараа, хуульд зааснаар УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг банкны байгууллагын бүтцийн өөрчлөлттэй холбогдуулж УИХ-ын дарга Р.Гончигдорж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл хийснийг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчжээ гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Зохицуулах зөвлөл байгуулах тухай УИХ-ын даргын 1996 оны 12 дугаар сарын 11-ний 104 тоот захирамжийг Ард, Даатгал банкыг татан буулгах үйл ажиллагаатай холбогдуулж гаргасан гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйл, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. УИХ-ын дарга Р.Гончигдоржийн гаргасан захирамж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр банкны өөрчлөлттэй холбогдуулж хийсэн мэдээлэл нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 2,3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчөөгүй байна.

2. Энэ дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоног багтаан хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг УИХ-д уламжилсугай.

Дарга

Г.СОВД

Гишүүд

Л.БААСАН  
Н.ЖАНЦАН  
С.ЖАНЦАН  
Д.ЧИЛХААЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1997 оны 3 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн  
нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10  
дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт  
Монгол Улсын Үндсэн хуулийг  
зөрчсөн эсэх маргааныг эцэслэн  
шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн Цэцийн хуралдааныг Цэцийн дарга Г.Совд даргалж, гишүүд Л.Баасан, Н.Жанцан, Ж.Бямбаа, С.Жанцан /илтгэгч/, Ж.Бямбажав, Д.Чилхаажав нар, нарийн бичгийн даргаар Б.Цэндэхүүг оролцуулан хийв.

Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд өргөдөл гаргагч иргэн С.Нарангэрэл, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Дэлгэрмаа нар оролцов.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хорооны иргэн С.Нарангэрэл Үндсэн хуулийн Цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө:

"Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан "Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг ... тухайн шатны хуралтай зөвшилцөн томилно." гэсэн хэм хэмжээ Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байгаа тул бүхэлд нь хүчингүй болгох зорилгоор энэхүү өргөдөл, тайлбарыг гаргав" гэжээ.

Иргэн С.Нарангэрэлийн өргөдөлтэй маргааныг Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж "Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн өргөдөлд дурьдсан заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг зөрчсөн байна" гэсэн 09 тоот дүгнэлт гаргажээ.

Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 09 тоот дүгнэлтийг УИХ-ын Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж, олонхийн саналаар тус дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэсэн тус тусын дүгнэлтүүдийг УИХ-д оруулсан байна.

Монгол Улсын Их Хурал Байнгын хороодын дүгнэлтүүдийг үндэслэж, Үндсэн хуулийн Цэцийн 09 тоот дүгнэлтийг 1997 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд, гишүүдийн

63 хувийн саналаар Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй байна гэсэн саналыг дэмжсэн боловч Цэцийн дүгнэлтийн талаар гарах УИХ-ын тогтоолын төслийг нэг гишүүн зөвшөөрч, 58 гишүүн эсэргүүцэн, батлаагүй хойшилж 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн хуралдаанаар дахин хэлэлцэн 11 дүгээр тогтоол гаргажээ.

Улсын Их Хурлын 11 дүгээр тогтоолд "Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 09 тоот дүгнэлтийг "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Үндсэн хуулиар тодорхой зохицуулалтгүй орхигдуулсан харилцааг нарийвчлан зааж өгсөн нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй учир хүлээн авах боломжгүй гэж үзсүгэй" гэж заажээ.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Дэлгэрмаа Үндсэн хуулийн Цэцэд бичгээр ирүүлсэн тайлбаргаа УИХ-аас дараахь үндэслэлээр Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

1. Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ" гэсэн зарчим үйлчлэх ёстой билээ. Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь орон нутгийн сонгуулиар бий болдог нутгийн өөрөө удирдах байгууллага буюу иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон иргэдийн Нийтийн Хурал байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулахыг хэлж байгаа юм. Эрх баригч хүнээс сонгуулийн дүнг хүндэтгэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгуулагдах, тэдгээрийн даргыг сонгоход ямар нэгэн байдлаар оролцсон явдал байхгүй болно.

Төрийн удирдлага гэдэг нь Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны заасан "Засаг дарга, засаг төрийн төлөөлөгчийн хувьд харьяа нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газар, харьяалах дээд шатныхаа байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах ажлыг Засгийн газар, дээд шатны Засаг даргын өмнө хариуцах зэрэг зарим утга агуулгаар тус тус илэрхийлэгдэж байна.

Эдгээрээс дүгнэж үзэхэд Засаг даргын томилгооны асуудал нь Үндсэн хуулийн агуулгаар бол тухайн үед засгийн эрхийг авсан олонхийн Засгийн газрын Ерөнхий сайдын эрх хэмжээний асуудал болох нь тодорхой. Дээрхи үндэслэлтэй холбоотой С.Нарангэрэлийн гаргасан өргөдөл нь хууль зүйн үндэслэлгүй болно...

... Өнөөдрийн томилогдон ажиллаж буй аймгийн Засаг дарга нарын намын гишүүнчлэлийг үзвэл МҮАН-аас 11, МАХН-аас 7,

МСДН-аас 4 хүн байна. Эхний удаа Ерөнхий сайд аймгийн ИТХ-аас нэр дэвшүүлснээс 7 хүнийг татгалзсаны 6 нь МАХН, 1 нь МУАН-ын гишүүд байсан. Эдгээрийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай зөвшилцсөний үндсэн дээр дахин нэр дэвшүүлж томилсон байгаа.

Энэ бүгдээс үзэхэд Ерөнхий сайдын зүгээс гагцхүү түүний Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх чадвар бүхий хүнийг өөрийн багтаа авч ажиллуулах зарчим голлосон болох нь тодорхой.

Үндсэн хуулийн утга санаа, үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд түүний гол баталгаа болох Үндсэн хуулийн Цэц шударга шийдвэр гаргана гэдэгт итгэж байна" гэв.

Нэхэмжлэгч иргэн С.Нарангэрэл Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож тайлбарлахдаа: "Миний бие өргөдөл гарган хэлэлцүүлээд 6 сар өнгөрлөө. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хууль зөрчсөн гэсэн өргөдлөөсөө татгалзаагүй. Иймд Үндсэн хуулийн Цэц шийдвэртэнэ гэдэгт итгэж байна" гэжээ.

УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Дэлгэрмаа Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд тайлбарлахдаа: "Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ" гэсэн зарчим үйлчлэх ёстой билээ. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ" гэсэн зарчим үйлчлэх ёстой билээ. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Дахин нэр дэвшүүлсэн хүнийг ... тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн заалт нь хоёр ба түүнээс дээш удаа гэсэн ойлголт учир Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэж байна" гэжээ.

#### ХЯНАВАЛ:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4-т буй "Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 3-т буй "Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга, доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшинчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална"



гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэстэй байна. Дээд шатны Засаг дарга нь зөвшилцөх зарчмаар доод шатныхаа Засаг даргыг томилох тухай хэм хэмжээ Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдаагүй байна.

Энэ талаар гарсан Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 1996 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 09 тоот дүгнэлт үндэслэлгүй байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3, Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Үндсэн хуулийн Цэцийн 09 тоот дүгнэлтийн тухай 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 11 дүгээр тогтоол, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "Дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн заалтыг тус тус хүчингүй болгосугай.

2. Энэхүү шийдвэр нь гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурьдсугай.

Дарга

Г.СОВД

Гишүүд

Л.БААСАН  
Н.ЖАНЦАН  
С.ЖАНЦАН  
Д.ЧИЛХААЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 11-ний өдөр

№237

Улаанбаатар  
хот

**Төрийн болон орон нутгийн өмчийн  
тухай хуулийн 56 дугаар зүйлийн 1  
дэх хэсгийн зарим заалтыг  
тайлбарлах тухай**

Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн зарим заалтыг доор дурьдсанаар тайлбарласугтай:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Биржийн гадуур арилжиж худалдана" гэдэгт Төрийн өмчийн хорооны шийдвэрээр хувьцаа, ногдол хувийг худалдах замаар хувьчлан хувьцаат компани болсон төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хувьцаа, ногдол хувийг чөлөөтэй болон багцалсан хэлбэртэйгээр уг хуулийн 38-45, 46-54, 58-р зүйлүүдэд заасан дуудлагын худалдаа, уралдаант шалгаруулалт, удирдах үйл ажиллагааны үр дүнг харгалзан хувьчлахын аль нэг аргаар хувийн өмчлөлд шилжүүлэх явдлыг хамааруулан ойлгоно.

2. Төрийн өмчийн үйлдвэрийн газар болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд оногдох хувьцаа, ногдол хувийг Төрийн өмчийн хорооны шийдвэрээр биржийн гадуур арилжиж худалдах ажиллагаа нь Үнэт цаасны тухай хуулийн 9-р зүйлийн 2 дэх хэсгийн заалтаар зохицуулагдах харилцаанд хамаарахгүй.

Ерөнхий шүүгч

Д.ДЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч

А.ДОРЖГОТОВ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар  
хот

Зарим тогтоол, тогтоолын заалтыг  
хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Шинжлэх ухааны талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 1997 оны 31 дүгээр тогтоол гарсантай холбогдуудан Засгийн газрын дараахь тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

1/ “Байгаль орчныг хамгаалах ажлын удирдлага, зохион байгуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” БНМАУ-ын Засгийн газрын 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 36 дугаар тогтоолын 2 дугаар зүйл;

2/ “Хөдөө аж ахуйн үндэсний их сургууль байгуулах саналыг зөвшөөрөх тухай” Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 101 дүгээр тогтоол;

3/ “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 234 дүгээр тогтоол.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Гэгээрдлийн сайд

М. ЭНХСАЙХАН  
Ч. ЛХАГВАЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 136

Улаанбаатар  
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Орон сууц хувьчлах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 118 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн “... хувьчлах асуудлыг” гэснийг “... хувьчилбал” гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Хууль зүйн сайд

М.ЭНХСАЙХАН  
Ж.АМАРСАНАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 7-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар  
хот

Нутгийн захиргааны талаар авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгах нь:

а/ Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөгтөлбөрийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хагас жил тутам дүгнэн тооцож ажилласугай;

б/ доод шатныхаа Засаг дарга нарын ажил хариуцах чадварыг дээшлүүлэх замаар төр, засгийн жинхэнэ төлөөлөгч болгон ажиллуулж, тэдний үйл ажиллагаанд хяналт тавьж зохих туслалцаа дэмжлэг үзүүлэхэд Тамгын газрын ажлыг чиглүүлсүгэй;

в/ төрийн албан хаагчдад тавих шаардлага, хүлээх хариуцлагыг өндөржүүлэх, тэдний зүгээс хариуцлага алдах, архи дан согтуурах, хувийн эрх ашгийг хичээж албан тушаалаа буруугаар ашиглах зэрэг зөрчил дутагдал гаргах яадлыг таслан зогсоож, хуулийг чанд мөрдүүлэх арга хэмжээ авсугай;

г/ орон нутгаа хөгжүүлэх, иргэдийн ахуй амьдралыг дээшлүүлэх, эдийн засгийн бие даасан байдлаа хангах хөгтөлбөртэй ажиллаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байсугай;

д/ холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, даалгаврын биелэлтийг хэрэгжүүлэхгүй байгаа нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, ажилтанд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажилласугай;

е/ өмчийн хэлбэр харгалзахгүйгээр орон нутагт ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг үйл ажиллагаагаа хууль тогтоомжийн хүрээнд зөв зохистой явуулахад чиглүүлэн, түүнд тавих хяналтыг өндөржүүлж, удирдлага зохицуулалтын шуурхай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх. Энэ ажилд Засаг даргын Тамгын газар, санхүүгийн болон мэргэжлийн хяналт шалгалтын албадын үйл ажиллагааг чиглүүлж ажилласугай;

ж/ иргэдийн нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн амгалан тайван амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд анхаарч зөрчил, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагааг уялдуулан чиглүүлж, дэмжлэг үзүүлэх болон олон нийтийн үүсгэл санаачилгыг өрнүүлэх, иргэдийг татан оролцуулах замаар эрчимтэй ажил зохион байгуулсугай;

з/ Хурал, Тэргүүлэгчдээс гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, тэдгээрийг шаардлагатай мэдээлэл болон ажлаа хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангах арга хэмжээ авсугай;

и/ баг, хорооны Засаг дарга нарын ажлыг шалгаж зааварлах, тэднийг ажиллах бололцоогоор хангах тодорхой арга хэмжээ авч ажилласугай.

2. Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарын тавьсан асуудлыг шуурхай авч үзэхийн хамт төвлөрлийг сааруулж, нутгийн захиргааг бэхжүүлэхтэй холбогдуулан цаашид орон нутгийн захиргааны байгууллагуудын бүтэц, орон тоо, төсөв зардалтай холбогдсон шийдвэр чиглэл өгөх асуудлыг зогсоох, шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанд танилцуулсны үндсэн дээр хэрэгжүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

3. Өөр аймаг, нийслэлд ажиллахдаа тухай бүр мэдэгдэх, гадаад оронд явахдаа ажлын удирдамж, томилолтын үр дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны бэлтгэлийг сайтар хангаж ажил хэрэгч шийдвэр гаргах зорилгоор Тамгын газар, хэлтэс, албад тэдгээрийн мэргэжилтнүүдийг ажлынх нь чиг үүргийн дагуу татан оролцуулж байхын дээр Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тайлан мэдээг Засгийн газарт ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвлөсүгэй.

5. Монгол Улсын Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагад сум, дүүрэг, аж ахуйн нэгж, байгууллагаас асуудлыг гаргахуу аймаг, нийслэлийн Засаг даргаар дамжуулан тавьж байх нь зүйтэй гэж үзсүгэй.

6. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Т. Лхагваад даалгах нь:

а/ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, гэрээний биелэлт, Тамгын газрын ажлын байдлыг жил бүр шалган зааварлаж арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авсугай;

б/ ажлын давхардлыг арилгах, төсөв, зардал хэмнэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор аймаг, нийслэлийн удирдлага, Тамгын газар, хэлтэс, байгууллагын ажилтнуудын семинар, сургалтыг яам, агентлагийн саналыг авсны үндсэн дээр зохицуулан зохион байгуулж байсугай;

в/ аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, жилийн тайланг нэгтгэн Засгийн газарт танилцуулж байсугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Өвөрхангай аймагт хийсэн шалгалтын дүнгийн тухай" Засгийн газрын 1992 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 75 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн "а", "б", "в", "г" заалт, "Баянхонгор аймагт хийсэн шалгалтын дүнгийн тухай" Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 61 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн "а" заалт, "Нутгийн захиргааны байгууллагуудын 1993 оны ажлын тайлангийн тухай" Засгийн газрын 1994 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 58 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "а", "б", "в" заалт, 2,5 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Сангийн сайд  
Хууль зүйн сайд

М. ЭНХСАЙХАН  
П. ЦАГААН  
Ж. АМАРСАНАА

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 140

Улаанбаатар  
хот

Байгаль орчны яамны үйл ажиллагааны  
стратегийн бүтцийн өөрчлөлтийн хөтөл-  
бөрийг зөвшөөрөх, тус яамны  
бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчны яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- а/Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар;
- б/Төрийн захиргаа, үнэлгээ, мэдээллийн газар;
- в/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- г/Хамтын ажиллагааны хэлтэс.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим яамдын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "д" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Байгаль орчны сайд

М.ЭНХСАЙХАН  
ЦАДЬЯАСҮРЭН

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### 1.0. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1. Оршил

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэнэ)-г Байгаль орчны сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдлага төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах болон бодлогын төлөвлөлт ба хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан хамгийн тохиромжтой үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

#### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын Төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

#### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
- Бусад хууль тогтоомж

#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

#### 1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Чиглэлийн яамдын нэг болох Байгаль орчны яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхимд үх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлдэг.

Байгаль орчны яам нь бодлого, төлөвлөлт, төсвийн зарцуулалтын эцэвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад нхаарлаа төвлөрүүлдэг.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий иглэлийн яамдын нэг болох Байгаль орчны яам нь Засгийн газрын айгаль орчны зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.


#### 1.6. Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын эрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу эрэгцлэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны гратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дараахь загварт харуулсан йлчлүүлэгч буюу хэрэгцлэгч хамрагдана:



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Байгаль орчны яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхим байна.

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дурьдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч бу

хэрэглэгчийн олон төрлийн нэрийн түвэгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, зааг хүрээг тодотгож төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## **2.0. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ**

### **2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар**

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар - Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Байгаль орчны сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### **2.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

Байгаль орчны яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Тогтвортой хөгжлийн үзэл санааны дагуу үндэсний экологийн стратегийг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой холбон хэрэгжүүлэх;

2. Байгаль орчны яам өөрийн харьяа, нэгжүүд болон чиглэлийн яам, нутгийн захиргааны аж ахуйн нэгж болон Засгийн газрын бус байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогоор уялдуулан зохицуулах;

3. Байгаль орчны яамыг төрийн хэргийг өндөр мэргэжлийн түвшинд явуулах чадвартай цомхон, чадварлаг байгууллага болгох;

4. Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг ажиглан шинжлэх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэж буй арга, механизм, нөөц баялгийн ашиглалтын бодлого, чиглэл, үр дагаврыг экологийн тэнцлийг хангах шаардлагад хэрхэн нийцэж буй талаас нь үнэлж цэгнэж стратегийн төлөвлөлтийн мэдээллийн арга, технологийг сайжруулах;

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

**Байгаль орчны яамны үйл ажиллагааны эрхэм зорилго:**

Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгод нийцүүлэн экологийн тэнцлийг хангаж тогтвортой хөгжлийн үндсийг бэхжүүлэх.

### 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Байгаль орчны яам нь эрхэм зорилганхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Байгаль орчны стратегийн удирдлага, төлөвлөлтийн чадварыг дээшлүүлэх

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх;

3. Байгаль орчны бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

Энэ зорилт нь байгаль орчны бодлого боловсруулалтын ахиц дэвшил, бодлогын удирдамжийн болон хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дагаврыг ашиглан шинжилж улмаар тэдгээрийн үр дүнд бодитой үнэлэлт, дүгнэлт өгөхөд оршино.

### 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Байгаль орчны яамны үйл ажиллагааны зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Байгаль орчны стратегийн төлөвлөлтийг сайжруулж хөтөлбөржүүлэх;

1.2. Орчны доройтлыг бууруулж нөхөн сэргээх ажлыг бодлогын удирдамжаар ханган хөтөлбөржүүлэх;

1.3. Байгалийн гэмшгийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны стратегийн төлөвлөлтийн чадварыг дээшлүүлэх;

1.4. Байгаль орчны олон улсын хамтын ажиллагааг бодлогын удирдамжаар хангах.

2.0. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Байгаль орчны удирдлагын чадавхийг сайжруулах;

2.2. Байгаль орчны салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

2.3. Байгаль орчны бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх;

2.4. Байгаль орчны мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх.

3.0. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг төлөвшүүлж хөгжүүлэх;

3.2. Стандарт, хөтөлбөр төсөл, хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах.

## 2.6. Үйл ажиллагааны зорилт

Байгаль орчны яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг байгаль орчны яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Байгаль орчны яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанар тодорхойлж байна:

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



### 3.0 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

#### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловрсуулахад баримтлах зарчим

Байгаль орчны яам нь үйл ажиллагааныхаа бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэцэд дор дурдсан зарчмыг баримтална:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх).

2. Эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээр нь ажлын уялдаа, ажиллах чадварын хувьд итгэл хүлээхүйц байх).

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (Байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайн яамны бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх).

4. Бүтцийн хувьд энгийн, ойлгомжтой байх зарчим (Яамны Төрийн нарийн бичгийн даргаас хэлтсийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн (гурваас дээшгүй) шат дамжлагатай байх).

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтооход дөхөмтэй байх зарчим (Байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохиистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, зохицуулах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг хангасан байх).

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим. (Тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар (таком)-т төрийн аливаа нөлөөлөлд автасгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх).

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны заагар, зохион байгуулалтын

бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажлын үр дүнг үнэлж, худалдан авах боломжтой байх).

### 3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан бүтцийн ерөнхий тогтолцооны зарчим болон Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн загварыг үндэслэн яам нь үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загвартай байна.

#### Байгаль орчны яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



### 3.3 Зохион байгуулалтын бүтэц

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийг тодорхойлов:

## **1. Стратегийн удирдлага төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд байгаль орчны стратегийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн үүргийг хүлээж, байгаль орчны стратегийн төлөвлөлтийг сайжруулах, орчны доройтлыг бууруулж нөхөн сэргээж ажлыг бодлогын удирдагчаар хангах, байгалийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны стратегийн төлөвлөлтийн чадварыг дээшлүүлэх, байгаль орчны болон олон улсын хамтын ажиллагааг бодлогын удирдагчаар хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдагчаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бүх шатны Засаг дарга нар тэдгээрийн тамгын газар байна.

## **2. Төрийн захиргаа, үнэлгээ, мэдээллийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, харилцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх байгаль орчны бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, байгаль орчны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, хэрэгжсэн бодлогын үр дүнд үнэлгээ өгөх, байгаль орчны мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэжсэн, цомхон албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангаж бодлого боловсруулах, түүний



хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар байна.

### **3. Бодлогын зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь яамны үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд байгаль орчны бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааг төлөвшүүлж хэрэгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, нутгийн захиргааны байгууллага байна.

### **4. Олон улсын төсөл, хамтын ажиллагаа эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, олон улсын төсөл боловсруулан санхүүгийн гадаад эх үүсвэр олж хэрэгжилтийг хангах, манай улсаас байгаль орчны салбарт нэгдсэн 7 Конвенци, гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг биелүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь байгаль орчны салбарын олон улсын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэнэ. Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь олон улсын байгууллагууд, гадаад орнууд, олон улсын төслийн үр дүгийг хүртэгсэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад харилцааны яам, Сангийн яам байна.

## ЯАМНЫ БҮТЦИЙН ҮНДСЭН НЭГЖИЙН ДАРГЫН АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаал:	Дарга
Нэгж:	Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар
Хэнд тайлагнах:	Төрийн нарийн бичгийн дарга

### ЗОРИЛТ

Байгаль орчны стратегийн удирдлагын бодлогын удирдамж, төлөвлөлт, мэргэшлийн зөвлөлгөөгөөр хангах.

### ҮНДСЭН ҮҮРЭГ

-Байгаль орчны сайд, Төрийн нарийн бичгийн даргыг стратегийн бодлого, төлөвлөлттэй холбоотой бүх мэдээллээр хангах, бодлогын хувилбар, санал боловсруулж танилцуулах;

-Байгаль орчны яамны мөргөлдөгч, сонирхогч талуудын хэрэгшээг стратегийн бодлого, хөтөлбөр, төсөл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга механизм талархи үзэл баримтлал, үндэслэл, үндсэн чиглэл, загвар тооцоогоор хангах;

-Яамны газар, хэлтэс, агентлагийг бодлогын нэгдсэн удирдамжаар хангах.

-Байгаль орчны бодлогын асуудлаар Засгийн газар, байгаль орчны яамны түвшинд удирдлагын оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл, цаг үеэ олсон үндэслэлтэй зөвлөлгөөгөөр хангах;

-Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн саналыг сайдын болон төрийн нарийн бичгийн даргын зөвлөл, ажлын төрлийн холбоотой яамдын саналыг авч Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

-Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн эдийн засаг-экологи, экологи-нийгмийн урт хугацааны нэгдмэл бодлого явуулах үзэл баримтлал, стандарт, технологи, эрх зүйн талтай орчныг бүрэлдэхэд дэмжлэг үзүүлэх;

-Газрын ажиглалтуудын бүтээгч, хамтат үйл ажиллагааг хангаж тэдний мэдлэг, мэргэшлийн түвшин, төрийн бодлого боловсруулах үр чадвар, сэтгэлгээг дээшлүүлэхэд мэргэшил, арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх;

-Газрын үйл ажиллагаанд зохион байгуулалтын соёл, удирдлагын тэргүүний арга, технологи нэвтрүүлж, өдөр тутмын ажлыг жонд, шуурхай удирдан зохицуулах;

-Газрын болон Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги (бизнес төлөвлөгөө)-ийг боловсруулж хэрэгжүүлэх ажлыг нэгтгэн зохион байгуулах.

**Боловсрол:** Дээд, магистр, дэд доктор

**Мэргэжл:** Төрийн захиргаа, менежмент, эдийн засагч, санхүүч

**Үр чадвар:** Макро түвшинд төрийн бодлого боловсруулж, задлан шинэслэх, нэгтгэн дүгнэх, судалгаа, төлөвлөлт хийх баг бүрдүүлж ажиллах эв дүйтэй, удирдлага, зохион байгуулалтын шинэ арга, барил, туршлагыг соргоогоор мэдэрч тусган нэвтрүүлэх чадвартай.

**Туршлага:** Төрийн захиргааны албанд болон эдийн засгийн төв байгууллагад 10-аас доошгүй жил, үүний дотор удирдах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан.

Албан тушаал:  
Нэгж:  
Хэнд тайлагнах:

Дарга  
Бодлогын зохицуулалтын газар  
Төрийн нарийн бичгийн дарга

## ЗОРИЛТ

Байгаль орчны нямны стратегийн удирдлага, төлөвлөлтийн шийдвэрийг боловсуулах, хангалт-шинэжлэгээ хийх, үнэлэлт, дүгнэлт өгөх үйл ажиллагааг бодлогын арга хэрэгслэлээр зохицуулан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

## ҮНДСЭН ҮҮРЭГ

-Төрийн захиргааны бусад байгууллагуудтай хамтран байгаль орчны бодлогын төлөвлөлт, эрх зүйн баримтлалын хэрэгжилтийг зохицуулах;

-Байгаль орчны сайд, Төрийн нарийн бичгийн даргад байгаль орчны бодлого, төлөвлөлтийн асуудлаар яам хоорондын хамтын ажиллагааг хангахтай холбогдсон санал, үндэслэл тавьж шийдвэрлүүлэх;

-Бодлогын зохицуулалтыг сайжруулах эдийн засаг, техник-эколог байгуулалтын арга, механизмыг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хүний болон санхүүгийн нөөцийг бүрдүүлж зохицуулах;

-Байгаль орчны бодлогын асуудлаар зохицуулалт хийлгэх саналаа ерөнхий чиг үүргийн байгууллагад мэдэгдэж ажлын үр дүнг тайлагнах;

-Байгаль орчны хоёр ба олон талын хамтын ажиллагаа, зохицуулалтыг сайжруулах асуудлыг нэгтгэн зохион байгуулах;

-Байгаль орчны яамны дотоод нэгжүүдийн бодлого, төлөвлөлт, мэдээллийн уялдаа, холбоог сайжруулж, стратегийн удирдлагыг үр ашигтай хялуулах нөхцөлийг бүрдүүлэх;

-Бодлогын зохицуулалт хийхтэй холбогдсон санал, эдийн засаг, технологийн удирдлага, зохицуулалтыг сайжруулах үндэслэл, төслийг төрийн нарийн бичгийн даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн бусад яамдын саналыг авч сайдын зөвлөлийн хурал, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

-Газрын ажиглалтуудын бүтээлч, хамтач үйл ажиллагаа, ажлын уялдааг хангаж, тэдний төрийн хэргийг зохицуулан зохион байгуулах үр чадвар, мэдрэмжийг дээшлүүлэхэд арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.

-Хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх эрх олгох, эрх авсан байгууллагын ажилд дэмжлэг үзүүлэх ажлыг зохицуулах;

-Газрын үйл ажиллагаанд зохион байгуулалтын соёл, удирдлагын тэргүүний арга, технологи нэвтрүүлж, өдөр тутмын ажлыг жигд, шуурхай удирдан зохион байгуулах;

-Газрын болон Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги (бизнес) төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

**Боловсрол:** Дээд, магистр

**Мэргэжэл:** Төрийн захиргаа, хуульч, менежмент, эдийн засагч

**Ур чадвар:** Махро түвшинээр төрийн бодлого боловсруулж, зохицуулах, үнэлэлт дүгнэлт өгөх чадвартай, ажил хэргийг удирдан зохион байгуулах авьяастай, байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах арга технологи, төрийн хэргийг явуулах ёс зүйг сайн мэддэг, бусадтай хамтран ажиллах, харилцан зөвшилцөх эв дүйтэй.

**Туриалаг:** Төрийн захиргааны байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан.

Албан тушаал:  
нэгж:

Дарга  
Төрийн захиргаа, үнэмлэх,  
мэдээллийн газар

Хэцэ тайлагнах:

Төрийн нарийн бичгийн дарга

## ЗОРИЛТ

Төрийн захиргааны удирдлага, үйлчилгээг сайжруулах, төрийн хууль тогтоомж хэрэгжих, ажалтнуудын амжиллах талтай орчин нөхцөлийг бүрдүүлэх, байгаль орчны бодлого, стандарт, технологийн хэрэгжилтийн явцыг ашиглан шинжилж түүний үр дагаварт үнэмлэх өгөх ажлыг зохион байгуулах, байгаль орчны стратегийн удирдлага, зохицуулалтыг мэдээллээр хангахад дэмжлэг үзүүлэх.

## ҮНДСЭН ҮҮРЭГ

-Сайд, төрийн нарийн бичгийн даргыг яамны аппаратын үйл ажиллагаатай холбогдсон зөв, цаг үеэ олсон мэдээллээр хангах;

-Засгийн газар, Тэнхим, Сайдын зөвлөлийн хурлаанаар хэлэлцэх асуудал болон сайд, төрийн нарийн бичгийн даргын гаргах шийдвэрийн төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлэх;

-Удирдах дээд байгууллага, сайд, төрийн нарийн бичгийн даргын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар мэдээлэл гаргах, тайлагнах;

-Яамны аппаратын дотоод болон агентлаг бусад яам, орон нутгийн байгууллагын хооронд ажлын байнгын уялдаа тогтоож, хамтын ажиллагааны үр дүнг сайжруулах, харилцааны тогтолцоог бүрдүүлэх;

-Яамны аппаратыг чадварлаг ажилтнаар бүрдүүлж, зөв байршуулах ажилтан нарын мэргэжлийн түвшинг дээшлүүлэх, ажлын үр дүнг нь үнэмлэх тэдний амжиллах нөхцөл, нийгэмийн баталгааг хангахад дэмжин туслал;

-Салбарын албан хаагчдыг мэргэшүүлэх, шинээр бэлтгэх, салбарын шагнал, урамшил олгох ажлыг зохицуулан зохион байгуулах;

-Яамны үйл ажиллагааны зардал, төсвийг жил бүр боловсруулж холбогдох газарт оруулж батлуулах, гүйцэтгэл хяналт тавих;

-Бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох ажлыг тодорхой бодлого, мөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

-Байгаль орчны стратегийн удирдлага, төлөвлөлтийн хэрэгжилтийн явц, зохицуулалтын арга, механизмны үйлчлэлийн нөлөөлийг ажиглан шинжлэх ажлыг мэргэжил, арга зүйн зөвлөлтөөсөөр хангах;

-Экологийн норматив, стандарт, орчинд халгүй технологи туршин нэвтрүүлж буй явцад дүн шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж, арга зүйн зөвлөлтөө өгөх;

-Байгалийн нөөц баялгийн эдийн засгийн үнэлгээ, орчинд нөлөөлөх байдлын экологийн үнэлгээний агуулгыг хөгжлийн төсөл, хөтөлбөрийн үндэслэлтэй харьцуулан шинэжлэх;

-Байгаль орчны бодлого төлөвлөлт, экологийн норматив, стандартын хэрэгжилтийн үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах;

-Мониторингийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн байгаль орчны бодлого, стандарт, технологийн боловсруулалтын түвшний талаар санал, зөвлөмж гаргах ажлыг зохион байгуулах;

-Байгаль орчны олон улсын хамтын ажиллагааны бодлогын төлөвлөлтийн түвшин, төслийн хэрэгжилтийн явц, үр дагаварт үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулах;

-Байгаль орчны стратегийн төлөвлөлтийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг хариуцах;

-Байгаль орчны яамны удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах, түүнийг бусад яам, газар, орон нутгийн мэдээллийн сүлжээтэй холбох арга зүй, техник зохион байгуулалтын асуудлыг хариуцах;

-Байгаль орчны бодлогын асуудлаар удирдлагын шийдвэр гаргах ажил мэдээллийн туслалцаа үзүүлэх;

-Байгаль орчны яамны үйл ажиллагааг олон түмэнд ил тод сурталчлах, мэдээлэх арга, хэлбэрийг сайжруулах;

-Байгаль орчны улсын мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

**Боловсрол:** Дээд, магистр, дэд доктор

**Мэргэжил:** Төрийн удирдлага, хуульч, эдийн засагч

**Ур чадвар:** Ажил хэргийн явцыг соргоогоор ажиглан мэдэрд төрийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх арга, технологийг сайн эзэмшсэн, ажлын явц, үр дүнд заалан шинэжлэх, нэгтгэн дүгнэх судалгааны арга барил сайтай, мэдээллийг тооцоолон болох техникт боловсруулж ашиглах, дамжуулах мэдлэг чадвар, арга технологи эзэмшсэн, төрийн хэргийг зохион байгуулах, зохицуулах азынастай, гадаад хэлний мэдлэг сайтай, хүнтэй ажиллах ур чадвартай, шурага, зарчимч, ажил хэрэгч.

**Туршлага:** Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан, шинэжлэх ухаан, мэдээлэл-технологийн ажилд толорхой хутагшагаар дадлагажсан.

Албан тушаал:	Дарга
Нэгж:	Хамтын ажиллагааны хэлтэс
Хэмд тайлагнах:	Сайд, Төрийн нарийн бичгийн дарга

## ЗОРИЛТ

Байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагааны болон олон улсын төслүүдийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх

## ҮНДСЭН ҮҮРЭГ

- Хоёр болон олон талын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх;
- Олон улсын төслийн санал боловсруулан саяхүүгийн гадаад эх үүсвэр олж хэрэгжүүлэх;
- Монгол улсын нэгдэн орсон 7 Конвенц, хөрш зэргэлдээ орнуудтай байгуулсан Засгийн газар хоорондын болон яамд хоорондын гэрээ, хэлэлцээрүүдийн хэрэгжилтийг хангах;
- Олон улсын хамтын ажиллагааны бодлого, чиглэл, төлөвлөлт, үйл ажиллагааны асуудлаар сайдад зөвлөмж өгч дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчны асуудал эрхэлсэн олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх;
- Олон улсын хурал, зөвлөлтөөнд төлөөлөгч оролцуулах, семинар сургалтад хүмүүсийг хамруулах, ийм төрлийн үйл ажиллагааг Монгол улсад зохион байгуулах;
- Байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагаа, олон улсын төслүүдийн үр өгөөжийг байнга дээшлүүлж байх;
- Олон улсын болон бүс нутгийн хөтөлбөрүүдэд идэвхитэй оролцох;
- Бодлого төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн саналыг сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын зөвлөл, ажил төрлийн холбоотой намдын саналыг авч Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Боловсрол: Дээд, магистр

Мэргэжил: Байгаль орчин, олон улсын харилцаа

Ур чадвар: Байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагааны хэрэгцээ, түүнээс хүртэж болох үр өгөөжийг мэдэрдэг, хэрхэн ашиглах талаар зохих мэдлэгтэй, олон улсын байгууллага болон хандивлагч орнуудын үзэл баримтлалыг сайтар ойлгодог, олон улсын харилцааны эрх зүйн болон дипломат ёс, жаягнийг эзэмшсэн, зохион байгуулах болон гадаад хэлний ахьяас чадвартай.

Туршлага: Төрийн захиргааны байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 141

Улаанбаатар  
хот

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны  
стратеги, зохион байгуулалтын бүтцийн  
өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх,  
тус яамны бүтцийг батлах  
тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Батлан хамгаалах яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а/Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар;

б/Төрийн захиргааны удирдлагын газар;

в/Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

г/Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;

д/Санхүүгийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Батлан хамгаалах яамны зохион байгуулалтын бүтэц, зардлын төсвийн хязгаар батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 194 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Батлан хамгаалахын сайд

Д.ДОРЛИГЖАВ



Засгийн газрын 1997 оны 141  
дүгээр тогтоолын хавсралт

## БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1.1. Оршил

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид "Хөтөлбөр" гэх)-т Батлан хамгаалахын сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

#### 1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

#### 1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль;

- Монгол Улсын Хилийн тухай хууль;
- Монгол Улсын Иргэний хамгаалалтын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын цэргийн номлол;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

#### **1.4. Арга зүй**

Хөгөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага; үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл; байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

#### **1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь**

Чиглэлийн яамдын нэг болох Батлан хамгаалах яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Батлан хамгаалах яам нь стратегийн бодлого, төлөвлөлт болон салбарын төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Батлан хамгаалах яам нь Засгийн газрын батлан хамгаалахын зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

#### **1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр**

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:



Батлан хамгаалах яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын танхим байна.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Батлан хамгаалах яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## 2.0. БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

### 2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүдэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Батлан хамгаалахын сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 2.2. Үйл ажиллагааны тэргүүдэх чиглэл

Батлан хамгаалах яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүдэх чиглэлтэй ажиллана:

1. Батлан хамгаалах яамыг стратегийн төлөвлөлт, бодлогыг удирдажаар хангах, хөтөлбөржүүлэх, зохицуулах, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиг үүрэгтэй төрийн захиргааны төв байгуудлага болгох замаар үйл ажиллагааных нь үр нөлөө, үр ашгийг эрс дээшлүүлэх;

2. Эдийн засгийн зах зээлийн харилцааны онцлогт нийцсэн улс орноо батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх;

3. Төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгуудлага, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэн төрөөс зохицуулах хууль, эрх зүйн үндсийг бий болгох;

4.Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, тайван цагийн бүтэц, бүрэлдэхүүнээрээ байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадвар бүхий анги салбаруудыг байгуулах;

5. Улсын хилийг мэргэжлийн албаны харуултай болгон, хилийн хамгаалалтыг бэхжүүлэх.

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

#### Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны эрхэм зорилго

Зэвсэгт хүчин, хилийн цэргийг мэргэжлийн чиг баримжаатай чадварлаг болгох, батлан хамгаалах улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлсний үндсэн дээр улс орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг найдвартай хангах

### 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Батлан хамгаалах яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах;
2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
3. Батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
4. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх.

### 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана.

#### 1.0. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

- 1.1. Батлан хамгаалах улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд зөвлөлгөө өгөх;
- 1.2. Зэвсэгт хүчин, Хилийн цэргийг мэргэжлийн цэргийн чиг хандлагатай чадварлаг болгон шинэчлэх үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;
- 1.3. Батлан хамгаалах салбарын эрдэм шинжилгээ, төсөв, цэргийн гадаад харилцааны хөтөлбөр, төслийг бодлогын удирдамжаар хангах.

#### 2.0. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- 2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
- 2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах.

3.0. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн зохион байгуулалт, сургалт бэлтгэл, дотоод алба, ахуйтай холбогдсон бодлогын хэрэгжилтийг эрх зүйн үүднээс зохицуулах;

3.2. Батлан хамгаалах салбарын байгууллагуудын хангалт, үйлдвэрлэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах;

3.3. Батлан хамгаалах үйл ажиллагааны сурталчилгаа, олон нийттэй харьцах бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

3.4. Батлан хамгаалах төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

4.0. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;

4.2. Батлан хамгаалах мэдээллийн сан байгуулах, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;

4.3. Батлан хамгаалах салбарын цэргийн анги, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад үзлэг, баримтын шалгалтыг зохион байгуулах, төсвийн зарцуулалтад хяналт, шалгалт, хяналт-шинжилгээ (мониторинг) хийх.


## 2.6. Үйл ажиллагааны зорилт

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

## Батлан хамгаалах намны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загвар



### 3.0. БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, САНАЛ БОЛГОЖ БҮЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

#### 3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх).

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, гэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх).

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх).

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл - аль болох цөөн /гурваас дээшгүй/ шаг дамжлагатай байх).

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэгтэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх).

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүдэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлдөд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлтөө, бүх талын дэмжлэг үзүүлэх).

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион




байгуулалтын бүтэц нь чадавхна бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

### 3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

#### БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Батлан хамгаалах яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

#### 1. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн I дүгээр зорилтын хүрээнд Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний стратегийн бодлого, цэрэг-стратегийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, батлан хамгаалах улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн гадаад харилцааны бодлого боловсруулж, хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчин, Хилийн цэргийг мэргэжлийн цэргийн чиг хандлагатай, чадварлаг болгон шинэчлэх үйл ажиллагааг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Ерөнхийлөгч-Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, Үндэсний Аюулгүй байдлын Зөвлөл, Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газар (Танхим) байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын гохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төрийн холбогдох бусад болон хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар байна.

## 2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүрэг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, харууллага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн цомхон албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Батлан хамгаалахын сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, цэргийн анги, байгууллагууд, нутгийн захиргааны байгууллага, төрийн холбогдох бусад байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байх болно.

## 3. Батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд батлан хамгаалах салбарын бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн сургалт, бэлтгэл, орон тоо, зохион байгуулалт, дотоод алба, ахуйтай холбогдсон бодлогын хэрэгжилтийг эрх зүйн үүднээс зохицуулах, батлан хамгаалах салбарын байгууллагуудын зэвсэг техник, материал

Хэрэгслэлийн хангалтын бодлогын хэрэгжилт, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зохицуулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Батлан хамгаалахын сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, батлан хамгаалах бодлого ба зөвсөглэл, техник, материал хэрэгслийн нөөцийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэнэ.

Энэ нь нөөцийг оновчтой хувиарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүдэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын холбогдох тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, олон нийт, цэргийн анги, байгууллага, төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгж байх болно. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Сангийн яам байна.

#### **4. Санхүүгийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд батлан хамгаалах төсвийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, батлан хамгаалах бодлого ба төсвийн тэнцвэрт байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь батлан хамгаалах бодлого ба төсвийн тэнцвэрт байдлыг хангахад чиглэнэ. Үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, Засгийн газрын холбогдох тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, цэргийн анги, байгууллага, төрийн өмчийн үйлдвэр, бусад аж ахуйн нэгж байх болно. Энэ үйлчилгээг үзүүлэхэд гол түнш нь Сангийн яам байна.

#### **5. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, батлан хамгаалах

бодлого, хөтөлбөр, төслүүд болон төсвийн бодлогын хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, хэрэгжсэн бодлогын үр дүнд үнэлгээ өгөх, цэргийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт, өмч хөрөнгийн үзлэгийг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Батлан хамгаалахын сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь цэргийн анги, байгууллага, бусад хэрэглэгчид байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, эрдэм шинжилгээний байгууллагууд болон тооцоолох төвүүд байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 142

Улаанбаатар  
хот

**Гэгээрлийн яамны үйл ажиллагааны  
стратегийн зохион байгуулалтын бүт-  
цийн өөрчлөлтийн хөтөлбөрийг  
зөвшөөрөх, тус яамны бүтцийг  
батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрале **ТОГТООХ** нь:

1. "Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Гэгээрлийн яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

- а/ Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газар;
- б/ Төрийн захиргааны удирдлагын газар;
- в/ Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;
- г/ Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар;
- д/ Хамтын ажиллагааны хэлтэс.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим яамдын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "г" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М. ЭНХСАЙХАН

Гэгээрлийн сайд

Ч. ЛХАГВАЖАВ

Засгийн газрын 1997 оны 142 дугаар  
тогтоолын хавсралт

**ГЭГЭЭРЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН  
ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР**

**1.0. Нийтлэг үндэслэл**

**1.1. Оршил**

Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-г Гэгээрлийн сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шижилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратегийн болон зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлов.

**1.2. Үндэслэл**

Хөтөлбөрийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ни баримт бичиг, Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Монгол Улсын Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэв.

**1.3. Хууль тогтоомжийн орчин**

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ :

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- "Боловсролын тухай" Монгол Улсын хууль;
- "Бага, дунд боловсролын тухай" Монгол Улсын хууль;
- "Дээд боловсролын тухай" Монгол Улсын хууль;
- "Соёлын тухай" Монгол Улсын хууль;
- "Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай" Монгол Улсын хууль;
- "Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай" Монгол Улсын хууль;
- Бусад хууль тогтоомж.

#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, еөрчлөлтийн удирдлага; үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл; байгууллагын еөрчлөлтийн зэрэг арга зүйг тус тус хэрэглэв.

#### 1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуяаарь

Чиглэлийн яамдын нэг болох Гэгээрлийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлтөө, дэмжлэг үзүүлднэ.

Гэгээрлийн яам нь салбарын бодлого, төлөвлөлтийн үндсэн чиг үүргийг хүлээж, бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлднэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Гэгээрлийн яам нь Засгийн газрын шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёлын зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.



## 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Гэгээрлийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход духал ач холбогдолтой юм. Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

### ГЭГЭЭРЛИЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Гэгээрлийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхим байна.

Гэгээрлийн яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн, нарийн түвэгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Гэгээрлийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын

ажлын байр (албан тусаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгах хэрэгжүүлнэ.

## 2.0. ГЭГЭЭРЛИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

### 2.1. Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Чиглэлийн яамдын нэг болох Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Гэгээрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Гэгээрлийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Гэгээрлийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Төрөөс шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёлын талаар баримтлах бодлого, хуулиуд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд сайдад бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
2. Яамны аппаратын үндсэн үйл ажиллагааг стратегийн төлөвлөлт, бодлогын удирдлагаар хангах, зохицуулах, хяналт-шинжилгээ (мониторинг), үнэлгээ хийхэд чиглүүлж, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
3. Яамны бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тогтоож, ажлын байрны давхардлыг арилгах, уялдаа холбоог сайжруулах, төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэн чадваржуулах замаар аппаратыг чадварлаг, цомхон алба болгох;
4. Яамны зүгээс үзүүлэх төрийн үйлчилгээг соёлтой, чанартай, шуурхай болгох.

### 2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Гэгээрлийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго

Монгол Улсын иргэд ардчилсан нийгэмд өөрсдийгөө бүрэн дүүрэн илрүүлэн амьдрах, ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, технологи болон соёлын үнэт зүйлсийг эзэмших, сонгох талтай орчин, нөхцөлийг бүрдүүлэх

## 2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Гэгээрлийн яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёл /НУТВС/-ын хөгжлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;
2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
3. НУТВС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
4. НУТВС-ын бодлогын хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.

## 2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. НУТВС-ын хөгжлийн бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахад зөвлөлтөө, дэмжлэг үзүүлэх;

1.2. НУТВС-ын хөгжлийн хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэхэд зөвлөлтөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

1.3. НУТВС-ын гадаад харилцаа, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хөгжүүлэхэд зөвлөлтөө өгөх, дэмжлэг үзүүлэх.

2.0. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. ШУТБС-ын төрийн захиргааны удирдлагын манлайлал, дотоод үйлчилгээгээр хангах;

2.2. ШУТБС-ын салбарын хүний нөөцийг зохистой ашиглахад зөвлөлгөө өгөх, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх.

3.0. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. ШУТБС-ын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах;

3.2. ШУТБС-ын салбарын материаллаг нөөц, сурах бичгийн хангамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.

4.0. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. ШУТБС-ын салбарын бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шигжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;

4.2. ШУТБС-ын мэдээллийн сүлжээ, мэдээллийн сан бүрдүүлэх, боловсруулалт хийх, мэдээллээр үйлчлэх.


2.6. Үйл ажиллагааны зорилт

Гэгээрлийн яамны үйл ажиллагааны дээр дурдсан гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Гэгээрлийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ийн стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

Гэгээрлийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ийн стратегийн загвар



3.0. ГЭГЭЭРЛИЙН ЯАМИН ҮЙЛ АЖИЛЛАГААНИ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ  
ТОГТОЛЦОО, САНАЛ БОЛГОЖ БҮЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ,  
ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Гэгээрлийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчим баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх).

2. Эрх мэдлийн зааг ялгаа нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэх болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх).

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны ажлын алба, түүний бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх).

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн /гурваас дээшгүй/ шат дамжлагатай байх).

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх).

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн


сайд, Засгийн газар (Танхим), бусад үйлчлүүлэгч буу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх).

7. Хангалттай чадвар, бодитой үйл ажиллагааны зарчим (Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхи бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Гэгээрлийн ламин үйл ажиллагаа (бизнес)-ий стратегийн загварыг үндэслэн тус лам үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загвартай байна:

Гэгээрлийн ламин үйл ажиллагаа (бизнес)-ий бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



### 3.3. Зохион байгуулалтын бүтэц

Гэгээрлийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ийн стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус яамны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгж урган гарч байна:

1. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Гэгээрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёл, урлагийн хөгжлийн бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, хөтөлбөр, төсөл боловсруулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Гэгээрлийн сайдынх нь хувьд түүнийг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлтөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бүх затны сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн болон эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бусад байгууллага байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тунш нь Сангийн яам, Хууль зүйн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.



2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Гэгээрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, уялдуулан зохицуулах, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг гадаад хамтын ажиллагааны мэдээлэл, үйлчилгээгээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Гэгээрлийн сайд болон Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, зуурхай зөвлөлгөө, орчуулга-үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гэгээрлийн сайд болон яамны Төрийн нарийн бичгийн дарга, газрууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бүх шатны сургууль, нэцэрлэг, соёл, урлагийн болон эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бусад байгууллага байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түүш нь Сангийн яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, гадаад орон, олон улсын байгууллага байна.

3. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж,

яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, харууллага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэссэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Гэгээрлийн сайдад болон яамны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургах хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гэгээрлийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бүх шатны сургууль, цэцэрлэг, соёл, урлаг, эрдэм шинжилгээний болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн удирдлага байна.

Үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь Хууль зүйн яам, Засгийн газрын Хөрөг эрхлэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, зарим чиглэлийн яамд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж биеллэх ухаан, технологи, боловсрол, соёлын салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохицуулах, салбарын материаллаг нөөцийн хуваарилалт, ашиглалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Гэгээрлийн сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нь Гэгээрлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгаа Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг болон холбогдох төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гэгээрлийн сайд, Засгийн газрын холбогдох тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь ШУТЭС-ын байгууллага, бусад аж ахуйн нэгж, иргэд бафна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнж нь Сангийн яам, Хууль зүйн яам, Гадаад харилцааны яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

5. Мэдээлэл, хяналт-шижилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шижилгээ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, шинжлэх ухаан, технологи, боловсрол, соёлын салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шижилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, мэдээллийн сунжээ, сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Гэгээрлийн сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн болон эрдэм шинжилгээний байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол тунг нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төв, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 144

Улаанбаатар  
хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Агаарын эвд нислэг үйлдэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Иргэний агаарын тээврийн нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах дүрэм"-ийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 196 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Дэд бүтцийн хөгжлийн сайд

Г.НЯМДАВАА

Байгаль орчны сайд

ЦАДЬЯАСҮРЭН

## ИРГЭНИЙ АГААРЫН ТЭЭВРИЙН НИСЛЭГИЙГ ЦАГ АГААРЫН МЭДЭЭГЭЭР ХАНГАХ ДҮРЭМ

### Нөг. Нийтлэг үндэслэл

1. Нислэгийн асуулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах зорилттой уялдуулан иргэний агаарын тээврийн агаарын хөлгийн нислэгийг (цаашид "нислэг" гэнэ) цаг агаарын мэдээгээр хангах, уг мэдээг ашиглах, мэдээний хангалт, ашиглалтад эрх бүхий байгууллагаас хяналт тавих харилцааг зохицуулахад энэхүү дүрмийг мөрдлөг болгоно.

2. Нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлын зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагын үүргийг Ус, цаг уур, орчны шинжилгээний газар /Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг/, нислэгийн цаг агаарын мэдээний ашиглалтын харилцааг зохицуулах уургийг Иргэний агаарын тээврийг удирдах газар /Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг/ тус тус гүйцэтгэнэ.

3. Иргэний агаарын тээврийн нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлыг эрхэлж байгаа байгууллагуудыг "мэдээгээр хангагч", уг мэдээг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа байгууллагуудыг "мэдээ ашиглагч" гэж тус тус нэрлэнэ.

4. Цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын асуудал хариуцсан агентлагууд нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах, уг мэдээг ашиглахтай холбогдсон ерөнхий гэрээг хоёр жилийн хугацаагаар байгуулна. Энэхүү ерөнхий гэрээг үндэслэн мэдээгээр хангагч, мэдээг ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжүүд өөр хоорондоо салбар гэрээ байгуулна.

5. Нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах, уг мэдээг ашиглахтай холбогдсон ажлын зохион байгуулалт, удирдлага, дэг журам, тавигдах шаардлагын хэрэгцээг тусгасан заавар, бусад баримт бичгийг цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын асуудал хариуцсан агентлагууд Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенц, энэхүү дүрэмд нийцүүлэн гаргаж өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх, мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.

6. Энэ дүрэм, ерөнхий гэрээ, бусад журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, тулгамдсан асуудлыг зохицуулан шийдвэрлэх эрх бүхий хамтарсан комиссыг агентлагууд; салбар гэрээ, түүнтэй холбогдсон асуудлыг зохицуулан шийдвэрлэх ажлын комиссыг хангагч болон ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжүүд тус тус байгуулж ажиллуулна. Тэдний ажиллах журмыг уг комиссыг байгуулсан агентлагууд батлан мөрдүүлнэ.

7. Мэдээгээр хангагч, мэдээ ашиглагч талуудын аль нэг нь нөгөө талын үйл ажиллагаатай шууд холбоотой техник, технологийг шинэчлэх, зохион байгуулалтын өөрчлөлт хийх, ажлын хүрээгээ өөрчлөх, заавар журам гаргах шаардлага гарвал төлөвлөлтийн үе шатанд нөгөө талдаа албан ёсоор мэдэгдэж үйл ажиллагаагаа зохицуулна.

8. Нислэгийн цаг уурын ажиглалтын станц харуулгүй буюу байгаа нэгж нь шаардлага хангахгүй бол мэдээ ашиглагч өөрийн санаачилга, хөрөнгөөр цаг уурын ажиглалтын түр буюу байнгын салбар байгуулан ажиллуулж болно.

9. Ашиглагч тал өөрийн хөрөнгөөр нислэгийн цаг уурын станц, харуул байгуулан ажиллуулсан тохиолдолд заавал цаг уурын мэргэжлийн хүмүүс ажиллуулна.

10. Нислэгийг цаг агаарын мэдээгээр хангахад шаартагдах багаж, төхөөрөмжийг худалдан авах зардлыг өдөөгээр хангагч тал улсын төсөвт тусгаж байна.

11. Агентлагууд нь энэхүү дүрэм, үүнтэй холбогдон гарсан журам, зааврын биелэлтийг хангах зорилгоор хангагч, ашиглагч байгууллага, аж ахуйн нэгжүүд тэр 2 жил тутамд нэг удаа хамтран залган зааварчилга хийнэ.

#### **Хоёр. Мэдээгээр хангагчийн үүрэг, эрх**

12. Мэдээгээр хангагч нь дор дурдсан үүрэгтэй байна:

а/ нислэгийг тухайн үеийн цаг агаарын бодит мэдээгээр хангах үүрэг бүхий ажиглалтын станц, аруулыг хөөрч, буух зурвасын ойролцоо байрлуулан жиллуулах;

б/ мэдээ ашиглагч талын цаг агаарын зураг, мэдээ-эй биечлэн танилцах болон нислэгийн цагийн хуваагийг баримтлах шаардлагад нийцүүлэн нисэх онгоцны уудлын дэргэд нислэгийг цаг агаарын урьдчилсан

мэдээгээр хангах үүрэг бүхий байгууллагуудыг байрлуулан ажиллуулах;

в/орон нутгийн нислэгт зориулсан цаг агаарын бодит болон урьдчилсан мэдээг өөрийн холбоогоор дамжуулах, хүлээн авах;

г/тухайн нисэх буудлын дэргэд урьдчилан мэдээлэх нэгж, салбаргүй болон тэдгээрийн ажиллагаа нь түр зогссон тохиолдолд мэдээний хангалтыг орон ажиллах нэгж, салбараар хавсран гүйцэтгүүлэх;

д/нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлыг дагнан буюу хавсран гүйцэтгэх орон тосонд зөвхөн мэргэжлийн инженер, техникч, ажиллагчдыг ажиллуулж, тэдний мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээг тогтмол авч байх;

е/нислэгийг цаг агаарын мэдээгээр хангахад Дэлхийн цаг уурын байгууллага, Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагаас гаргасан олон улсын стандарт, мэдээ ашиглагч талтай хамтран баталсан журам, заавар, гэрээг чанд мөрдөж ажиллах;

ж/дангаараа буюу мэдээ ашиглагч талтай хамтран холбогдох заавар журамд өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах, шинжилгээ, судалгааны ажил хийх, шинэ техник, технологийг зуурхай нэвтрүүлэх замаар нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлын чанарыг байнга сайжруулах;

з/агаарын хөлгийн осол, сүйрэл тохиолдсон, эсвэл ийм нөхцөл байдал бий болсонтой холбогдсон шалтгааныг судлан тогтооход мэргэжлийн хүмүүсийг томилон ажиллуулах, шаардагдах мэдээ, дүгнэлтийг гаргаж өгөх.

13. Мэдээгээр хангагч дор дурдсан эрхтэй байна:

а/цаг агаарын байдлаас шалтгаалан нислэгийн саатал, зөрчил, осол, сүйрэл гарсан тухай тодруулахын тулд мэдээ баримт материалыг авч танилцах, тодорхойлолт, магадалгаа гаргуулах;

б/нислэгийн цаг агаарын мэдээний ашиглалттай холбогдон нислэгийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлөхүйц зөрчил илэрвэл шалтгааныг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжийн эрх бүхий албан тушаалтанд урьдчилан мэдэгдэж, мэдээний хангалтыг түр зогсоох хүртэл арга хэмжээ авах;

в/нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах үүрэг гүйцэтгэж байгаа мэдээ ашиглагч талын цаг уурын багаж, төхөөрөмжийн баталгаа, тэнд ажиллаж буй хүмүүсийн мэргэжлийн түвшинг шалгаж дүгнэлт гаргах,

Заталгаагүй багаж төхөөрөмж ашиглахыг зогсоох, өргөжлийн бус болон холбогдох дүрэм, журам, заавар өөрчсөн хүмүүсийг өөрчлөх, хариуцлага хүлээлгэх тухай саналыг зохих шатны байгууллага, албан тушаалтанд тавих.

#### Гурав. Мэдээ ашиглагчийн үүрэг, эрх

14. Мэдээ ашиглагч дор дурдсан үүрэгтэй байна:

а/иргэний агаарын тээврийн хөлгөөр агаарын зайд нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах, нислэгийн тогтмолжилтыг дээшлүүлэхэд цаг агаарын эдээ, мэдээллийг бүтээлчээр ашиглах;

б/цаг агаарын мэдээ, мэдээлэл авахгүйгээр агаарын өлгөөр агаарын зайд нислэг үйлдэхгүй байх, олбогдох дүрэм, журам, зааврыг чанд мөрдөх;

в/нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлыг агнаан гүйцэтгэгч хангагч талын ажиллагчдыг ажлын айр, дулаан, цахилгаан, харилцаа холбоогоор ангахын зэрэгцээ ажилтнуудад ажлынх нь үр дүнгээр рамжил олгож, ажилдаа ирж, очиход нь унаамы өнгөлөлт үзүүлэх;

г/нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлыг авсран гүйцэтгэгч мэдээгээр хангагч талын ажилтнуудад ажлынх нь үр дүнгээр урамжил олгож, нислэгийг цаг агаарын мэдээгээр хангах ажлаар илүү цаг жилласан бол илүү цагийн хөлс олгох;

д/нислэгийн цаг агаарын мэдээний чанар, үр ашгийг эвслүүлэхэд чиглэгдсэн шинжилгээ, судалгааны ажил вуулахад нь мэдээгээр хангагч талд дэмжлэг үзүүлж, эдэнтэй хамтран ажиллах байх;

е/нислэгийн замын судалгаа гаргах, нислэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалттай холбогдсон суудлаар шалгалт хийх үүрэг бүхий хангагч, шиглагч талуудын хамтарсан комиссын бүрэлдэхүүнд рсон мэдээгээр хангагч талын хүмүүсийн агаарын өлгөөр зорчих зардлыг хариуцах;

ж/нислэх баг, нислэгийн удирдагч нарт цаг агаарын эдээ, мэдээллийг үр бүтээлтэй ашиглах мэдлэгийг ээмүүлж, тэдний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх рга хэмжээг тогтмол авч байх;

з/шинээр нисэх буудал, агаарын зам нээх тохиол- рлд цаг агаарын мэдээний хангалтын асуудлыг элөвлөлтийн үе шатанд тавьж шийдвэрлүүлэх.

15. Мэдээ ашиглагч дор дурдсан эрхтэй байна:



а/нисклэгийн цаг агаарын мэдээний хангалт нь нисклэгийн аюулгүй байдлыг хангах, нисклэгийн тогт-молжилтын шаардлагад илт нийцээгүй байвал хангагч талын удирдлагад урьдчилан албан ёсоор мэдэгдэж, нисклэгийг түр хугацаагаар зогсоох бөгөөд албан үүргээ хангалтгүй биелүүлж байгаа тухай харьяалах дээд байгууллагад нь мэдээлэх;

б/мэдээгээр хангагч талын ажилтнууд холбогдох дүрэм, заавар, журмыг удаа дараа зөрчих, нисклэгийн саатал, зөрчил гаргавал тэдэнд олгох урамшил, хөнгөлөлтийг бууруулах, хасах, улмаар тэдэнд арга хэмжээ авахуулах тухай саналаа хангагч талын удирдлагад тавих;

в/мэдээгээр хангагч талын холбогдох ажилтанд нисклэгийн цаг агаарын мэдээний хангалтын асуудлаар мөрдөж буй хууль тогтоомж, заавар, журамд нийцсэн шаардлага тавих.

### Дөрөв. Хяналт, хариуцлага

16. Энэхүү дүрмийн биелэлт болон нисклэгийн цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтын ажилд хөнд-лөнгийн хяналт тавьж ажиллах үүргийг Дэд бүтцийн улсын хяналтын алба гүйцэтгэнэ.

17. Нисклэгийн саатал, зөрчил, осол, сүйрэл нь цаг агаарын мэдээний хангалтаас шалтгаалсан бол хариуц-лагыг мэдээгээр хангагч тал, мэдээний ашиглалтаас шалтгаалсан бол мэдээ ашиглагч тал тус тус хүлээнэ.

18. Цаг агаарын мэдээний хангалт, ашиглалтаас шалтгаалсан нисклэгийн саатал, зөрчлийн актыг мэдээ-гээр хангагч, мэдээ ашиглагч талууд хамтран тогтооно. Харин иргэний агаарын тээврийн хөлгийг осол, сүйрэлд хүргэж болзошгүй нөхцөл байдал биэ болсон буу осол, сүйрэл тохиолдсон шалтгааны тухай актыг Засгийн газар эсвэл Дэд бүтцийн улсын хяналтын албанаас томилогдсон комисс тогтооно.

19. Энэ дүрмийг зөрчсөн албан тушаалтан, ажилтан; "Агаарын зайд нисклэг үйлдэх тухай Монгол Улсын хууль"-ийн 32 дугаар зүйл болон Монгол Улсын бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлагы хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 18-ны өдөр      Дугаар 148

Улаанбаатар  
хот

### Автомашин түрээслүүлэх журмыг батлах тухай

Төсвийн хөрөнгийг хэмнэх болон Төр, засгийн үйлчилгээний авто баазын парк шинэчлэхэд шаардагдах хөрөнгийг бий болгох зорилгоор "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" Монгол Улсын хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Төр, засгийн үйлчилгээний авто баазын автомашин түрээслүүлэх журмыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 266 дугаар тогтоолоор баталсан хавсралтын "жич" гэдгийн "а/"-д "...Дэд бүтцийн хөгжлийн болон Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Тамгын хэлтэст тус бүр 4 хүртэл, бусад яамдын Тамгын хэлтэст тус бүр 2 хүртэл ..." гэсэн хэсгийг " Дэд бүтцийн хөгжлийн болон Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны Тамгын хэлтэст тус бүр 2, бусад яамдын Тамгын хэлтэст тус бүр 1" гэж өөрчилсүгэй.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХСАЙХАН

Хууль зүйн сайд

Ж.АМАРСАНАА

Засгийн газрын 1997 оны 148  
дугаар тогтоолын хавсралт

### АВТОМАШИН ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЖУРАМ

Төр, засгийн үйлчилгээний авто баазын машин, техникийн ашиглалтыг сайжруулж, сул зогсолт, үр ашиггүй гүйлтийг багасгах зорилгоор олон жил ашиглагдсан зарим автомашиныг түрээслүүлж түүний орлогоор парк шинэчлэлт хийхэд энэхүү журмыг удирдлага болгоно.

### Нэг. Түрээслүүлэгчийн үүрэг

1. Түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ чанд биелүүлж, өөрийн буруугаас учирсан хохирол, саатал, түүнээс үүдсэн зардлыг хариуцна.

2. Түрээслэх автомашины техникийн бүрэн бүтэн байдалд комиссын үзлэг хийж акт үйлдэн түрээслүүлэгч болон түрээслэгч хоёр тал гарын үсэг зуран албан ёсоор автомашиниг хүлээлгэн өгнө.

3. Түрээслэгчийн хүсэлтээр түрээсийн автомашиниг баазын гараavid үнэ төлбөргүй тавиулна.

4. Эрүүл мэнд, нийгмийн даатгал, хүн амын орлогын татвар, замын хураамж зэрэг татварыг түрээслэгчидтэй тохиролцсон гэрээний дагуу хариуцна.

### Хоёр. Түрээслүүлэгчийн эрх

5. Түрээсээр ажиллах автомашин, жолоочийг шилж сонгоно.

6. Түрээсээр ажиллах автомашины техникийн бүх үзүүлэлтийг нарийвчлан гаргаж ашиглалтын түвшин тогтооно.

7. Түрээсээр ажиллах автомашины түрээсийн гэрээний хугацаа, жил болон нэг сард оруулах орлогын хэмжээг тогтооно.

8. Хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар тохиролцсон хугацаанд орлогоо оруулаагүй тохиолдолд түрээслэгчтэй байгуулсан гэрээг өөрийн санаачилгаар цуцалж авто-машины элэгдэл, ашиглалтыг тооцож түрээсэлсэн авто-машинаа эргүүлэн авч болно. Хэрэв түрээслэгчийн буруугаас автомашин гэмтэж цаашид ашиглах боломжгүй болсон бол түрээслэгчээс түрээсийн хугацаанд өгөх төлбөрийг бүрэн төлүүлнэ.

9. Түрээслэгч түрээсийн төлбөрөө гэрээнд заасан хугацаанаас өмнө төлбөл удирдах байгууллагад албан ёсоор мэдэгдэж уг автомашиниг хугацаанаас нь өмнө түрээслэгчид шилжүүлнэ.

### Гурав. Түрээслэгчийн үүрэг

10. Түрээсийн автомашины техникийн бүрэн бүтэн байдал, хамгаалалт, аюулгүй ажиллагааны талаархи асуудлыг хариуцна.

11. Түрээслүүлэгчтэй байгуулсан гэрээнд заагдсан үүргээ чанд биелүүлэх бөгөөд өөрийн буруутай үйлд-

лээс автомашинд учирсан хохирол, түүнтэй холбоотой асуудлыг өөрөө хариуцна.

12.Түрээсэлсэн автомашины бүх засвар үйлчилгээг хариуцах бөгөөд үүнээс үүдэн гарах сул зогсолт нь түрээсийн гэрээний үүргийн биелэлтэд нөлөөлөхгүй.

13.Үйлчилгээний соёл, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөлийг өөрөө хангана.

14.Түрээслэгч нь төр, засгийн үйлчилгээний байгууллагыг төлөөлөхгүй.

### Дөрөв.Түрээслэгчийн эрх

15.Түрээслүүлэгчийн зүгээс буруу шийдвэр болон дүгнэлт гаргавал гомдол, саналаа дээд шатны болон хууль хяналтын байгууллагад гаргаж шийдвэрлүүлнэ.

16.Өөрийн хөдөлмөр зохион байгуулалт, үйл ажиллагааны үр дүнд гэрээнд тусгагдсан үзүүлэлт, хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд холбогдох тооцоо, судалгаагаа нягтлан хийж хоёр тал гэрээгээ дүгнэсний эцэст түрээсэлсэн автомашинаа хувьдаа авна.

17.Хөдөлмөр зохион байгуулалтаа хариуцаж, ажлын цагаа өөрөө тогтооно.

18.Хүндэтгэн үзэх шалтгаантай бол түрээслүүлэгчээс зайлшгүй туслалцааг авч болох бөгөөд төлбөр тооцоог хоёр тал жич шийдвэрлэж байна.

19.Түрээслэгч нь түрээсийн хугацаанд түрээслүүлэгч авто баазын жолоочид тооцогдон байгууллагын зүгээс зохиож буй ажилд оролцох бөгөөд өмгөөлөл авах эрхтэй байна.

### Тав.Хоряглох зүйл

20.Автомашин түрээслүүлэгч, түрээслэгчид доорхи зүйлийг хориглоно:

а/түрээсийн автомашины гүйлт, ашиглалтын талаар гаргах тооцоо, түрээсийн явцад хийгдэх дүн мэдээг судлиантуулах, хагас дутуу хийх;

б/түрээсийн орлого болон автомашиныг өр зээлийн яарьцаанд өгөх;

в/үнэ төлбөргүйгээр буюу зах зээлийн тухайн үеийн аншаас доогуур (хэрэв гэрээнд заагдаагүй бол) нээр түрээсийн автомашинд сэлбэг материал олгох, свэл төр, засгийн үйлчилгээний бусад машин техникийн сэлбэг хэрэгслийг сольж тавих, түр хэрэглүүдэх

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 149

Улаанбаатар  
хот

Зарим тогтоол, тогтоолын заалт хүчингүй  
болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Импортын барааны гаалийн албан татварын тухай”  
Монгол Улсын Их Хурлын 1997 оны 4 дүгээр сарын 18-  
ны өдрийн 24 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан  
хавсралтад дурдсан тогтоол, тогтоолын заалтыг  
хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Сангийн сайд

М.ЭНХСАЙХАН  
П.ЦАГААН

Засгийн газрын 1997 оны 149  
дүгээр тогтоолын хавсралт

### ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАРИМ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

1. “Тогтоолын хавсралтыг шинэчлэн батлах тухай”  
1994 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 127 дугаар  
тогтоол.

2. “Үзэсгэлэнгийн талаар авах зарим арга хэмжээний  
тухай” 1994 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 172  
дугаар тогтоол.

3. “Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгийн  
татварын тухай” 1994 оны 12 дугаар сарын 7-ны  
өдрийн 200 дугаар тогтоол.

4. “Гааль, худалдааны татвараас хөнгөлөх тухай”  
1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 219 дүгээр  
тогтоол.

5. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”  
1995 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 32 дугаар  
тогтоол.

6. “Дархан хот дахь Хар төмөрлөгийн үйлдвэрийн  
санхүүгийн чадварыг дээшлүүлэх талаар авах зарим  
арга хэмжээний тухай” 1995 оны 3 дугаар сарын 22-ны  
өдрийн 42 дугаар тогтоолын 2, 3 дугаар зүйл.

7. "Гааль, худалдааны татвараас хөнгөлөх тухай" 1995 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 159 дүгээр тогтоол.

8. "Гурилд ногдуулах гаалийн албан татварыг хөнгөлөх тухай" 1995 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 92 дугаар тогтоол.

9. "Гурилд ногдуулах гаалийн албан татварыг хөнгөлөх тухай" 1995 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 129 дүгээр тогтоол.

10. "Тогтоолын хүчинтэй байх хугацааг сунгах, хүнсний улаан буудайд ногдуулах гаалийн татварыг хөнгөлөх тухай" 1995 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 189 дүгээр тогтоол.

11. "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах, худалдааны албан татвар ногдуулж байх тухай" 1996 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 7 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйлийн "... гаалийн албан татвараас чөлөөлөх ..." гэсэн хэсэг.

12. "Гааль, худалдааны албан татварыг хөнгөлж, чөлөөлөх тухай" 1996 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 61 дүгээр тогтоол.

13. "Нефтийн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай" 1996 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 69 дүгээр тогтоол.

14. "Хөнгөлөлттэй зээлээр нийлүүлсэн автобус, троллейбусны худалдааны болон гаалийн албан татварын тухай" 1996 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 110 дугаар тогтоолын 2 дугаар зүйл.

15. "Зарим тоног төхөөрөмжийн гааль, худалдааны албан татварыг чөлөөлөх тухай" 1996 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 124 дүгээр тогтоол.

16. "Худалдааны албан татвар болон гаалийн татварын тухай" 1996 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолын "... тэдгээрийн гаалийн татварын төлбөрийг хоёр сарын хугацаагаар хойшлуулсугай" гэсэн хэсэг.

17. "Гаалийн татварын тухай" 1996 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 330 дугаар тогтоол.

18. "Гааль, худалдааны албан татварыг бууруулах, чөлөөлөх тухай" 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 48 дугаар тогтоолын "... импортын гурил, үрийн болон таваарын буудайн гаалийн татварыг 50 хувиар бууруулж, мөн ..." гэсэн хэсэг.

19. "Тогтоолын хүчинтэй байх хугацааг сунгах тухай" 1996 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 142 дугаар тогтоол.

20. "Булчин задрах гоц халдварт өвчинтэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 1996 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 255 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн "...гааль ..." гэснийг хасах.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1997 оны 6 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 151

Улаанбаатар  
хот

Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги,  
зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн  
хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг"-ийг хавсралтын ёсоор зөвшөөрсүгэй.

2. Хууль зүйн яамны зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар баталсугай:

а/ Эрх зүйн шинэтгэлийн стратегийн удирдлага, нэгдсэн төлөвлөлтийн газар;

б/ Төрийн захиргааны удирдлагын газар;

в/ Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар;

г/ Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар.

3. Хууль зүйн сайдын тэргүүддэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, Гадаадын иргэдийн асуудал эрхлэх зөвлөл, Гэмт хэрэгтэй тэмцэх бодлого зохицуулалтын албыг баталсан төсөвт нь багтаан тус яамны үндсэн бүтцэд оруулахгүйгээр холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллуулахыг Хууль зүйн сайд Ж. Амарсанаад зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим яамдын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1996 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн 182 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн "ж" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд  
Хууль зүйн сайд

М. ЭНХСАЙХАН  
Ж. АМАРСАНАА

## ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН Х Ө Т Ө Л Б Ө Р

### 1. Нийтлэг үндэслэл

#### **1.1. Оршил**

Монгол Улсын Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, зохион айгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" эх/-т Хууль зүйн сайдын болон Засгийн газрын Төнхимын шийдвэрийг оновсруулан гаргах, хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны дирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-инжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрх зүйн мэдээлэл, гурталчилгааг бүх иргэдэд хүргэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрхийг баталгаажуулах ажлыг нийт хүн амд хүргэх, гэмт хэрэг, хэв журмын эрчилтэй тэмцэж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хүний эрхийг эмгaalахтай холбоотой асуудлыг хамарсан Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлох.

#### **1.2. Үндэслэл**

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор иэвээрсэн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны илгэл, бүтцийн өрөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн алаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 15 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх зэрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн эрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн төлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" гэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "ууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өрөнхий гевэр" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

#### **1.3. Хууль тогтоомжийн орчин**

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний ирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.



#### 1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (Бизнес)-ны төлөвлөлт болон эхн инженерчлэл, байгууллагын өөрчлөлт зэрэг арга зүйг хэрэглэв.

#### 1.5. Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Хууль зүйн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Хууль зүйн сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлтөө, дэмжлэг үзүүлнэ.

Хууль зүйн яам нь эрх зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөлтийн болон бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаж холбоог хангах асуудалд Засгийн газрын өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцдог удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Хууль зүйн яам нь Засгийн газрын хуулийн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

#### 1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Хууль зүйн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарагдана:

### ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Хууль зүйн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Хууль зүйн ийд, Засгийн газрын Танхим болно.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг ангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн түвэгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Хууль зүйн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг ангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус үрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн эрилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (**албан тушаал**)-ы тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

## 2. Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги

### **2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар**

Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны этөлбөр, Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Хууль зүйн сайдын үйл ажиллагаанд үлэр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын нөхцөл үзүүлэхэд оршино.

### **2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл**

Хууль зүйн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана.

1. Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого зөвшөөрүүлэх, хэрэгжүүлэхэд яамны болон тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааг төвлөрүүлэх, эрх зүйн нөхцөл, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах замаар Хууль зүйн ийд, Засгийн газар /Танхим/-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр шийг дээшлүүлэх;

2. Яамны хэмжээнд удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, иргэн ийгууллагад үзүүлэх хууль зүйн үйлчилгээний чанарыг олон исын жишигт хүргэх;

3. Хууль зүйн яамны өөрчлөлт, хөгжлийн стратегитэй уялдсан ний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэглэх, төрийн албан агчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах замаар яамны аппаратыг цомхон, чадварлаг болгон өөрчлөн хөгжүүлэх;

4. Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлагийн хэмжээнд өртөг, зардлыг бууруулах болон үйлчилгээний чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн нийтлэг үйлчилгээг ий болгон хөгжүүлэх.

### **2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго**

**Хууль зүйн яамны эрхэм зорилго**  
**Монгол Улсын бүх иргэн хүмүүнлэг, иргэний**  
**ардчилсан нийгэмд Үндсэн хуулиар тогтоосон**  
**үүргээ биелүүлэх, эрх, эрх чөлөөгөө баталгаатай**  
**эдлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх**

#### **2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт**

Хууль зүйн яам эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үй ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Эрх зүйн шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, бодлогь удирдамжаар хангах;
2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
3. Эрх зүйн шинэтгэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;
4. Эрх зүйн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгь /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.

#### **2.5. Үйл ажиллагааны гол зорилт**

Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрий хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үй ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

- 1.0 Үйл ажиллагааны стратегийн 1 дугаар зорилтын хүрээнд.
  - 1.1 Эрх зүйн шинэтгэлийн стратегийг төлөвлөх;
  - 1.2 Үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох;
  - 1.3 Эрх зүйн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.
- 2.0 Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд.
  - 2.1 Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагын манлайллы хангах, дотоод үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх;
  - 2.2 Сайдад болон аппаратад шийдвэр боловсруулан гэргахэд э зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх;
  - 2.3 Яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүт тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох.
- 3.0 Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд.
  - 3.1 Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
  - 3.2 Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;
  - 3.3 Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах.
- 4.0 Үйл ажиллагааны стратегийн 4 дугаар зорилтын хүрээнд.
  - 4.1 Эрх зүйн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгь /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;
  - 4.2 Хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хий үнэлгээ өгөх;
  - 4.3 Эрх зүйн үйлчилгээний үр нөлөөнд хяналт-шинжилгь /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.


#### **2.6. Үйл ажиллагааны зорилт**

Хууль зүйн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус я тодорхойлж хэрэгжүүлнэ.

## 2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Хууль зүйн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дурдсанаар тодорхойлж байна.

### ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА (БИЗНЕС)-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



3. Хууль зүйн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

**3.1. Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим**

Хууль зүйн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараахь зарчмыг баримтлав:

1. Зэсгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтыг бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх).

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц бай зарчим (бүтцийн нэгж, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэ нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эр мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлы уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх).

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагы баримжаатай байх зарчим (тухайн яамны нэр, бүтцээс үй ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны зохио байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх).

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарий бичгийн даргаас доод нэгжээ хүртэл аль болох цөөн /3-аас илүүгүй/ шат дамжлагатай байх).

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, шуурхай удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчто бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ н удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилж хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх).

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамн төрийн захиргааны албан хаагч нь Сайд, Зэсгийн газар (Тэнхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байх).


7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үй ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэж хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

**3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар**

Дээр дурдсан зарчим болон Хууль зүйн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагаан

Бүтцийн ерөнхий тогтолцооны дор дурдсан загварыг санал болгож байна.

### ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



### **3.3. Зохион байгуулалтын бүтэц**

Хууль зүйн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

#### **1. Эрх зүйн шинэтгэлийн стратегийн удирдлага, нэгдсэн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний эрх зүйн шинэтгэлийг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, эр зүйн шинэтгэлийн стратегийг төлөвлөх, үндэсний эрх зүйн тогтолцоо боловсронгуй болгох, эрх зүйн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Хууль зүйн сайд, Засгийн газрыг Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Хууль зүйн сайд, Засгийн газрын Танхимын стратегийг төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрыг гишүүн, Хууль зүйн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээ хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүйн сайд, Засгийн газар /Танхим/ байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Улсын Их Хурал, бусад яам, Засгийн газрыг тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргаан байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрх эрхлэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам байна.

#### **2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагыг манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагааны удирдлагын шилдэг тэргүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүн нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагна хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн алба хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамн тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ нь Хууль зүйн сайдад болон яамны аппаратад шийдвэр зөвшөөрүүлэн гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, ирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, ршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургаж ижүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, киллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүйн ийд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын тцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд с хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, рэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төсвийн йгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Сангийн яам, Засгийн зрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм өжилгээний байгууллага байна.

### **3. Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг**

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд х зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хицуулах үндсэн үүрэг хүлээж, эрх зүйн сургалт, сурталчилгааны лыг зохион байгуулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохион байгуулах, хицуулах, эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах зэрэг үндсэн г үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Хууль зүйн сайдын логын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, рилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ.

Энэ нь төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах маар бодлого, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай шийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагааг бодлого, төлөвлөгөө, гөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах маар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүйн йд, Засгийн газар /Танхим/, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч нтлаг, шүүх, прокурорын болон нутгийн захиргааны байгууллага байх гөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яамд, звийн байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн болон Засгийн газрын : байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг лэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам байна.



#### 4. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх үндсэн үүрэг хүлээж, эрх зүйн бодлогын болон хуулийн хэрэгжилтийн явц, байдал, эрх зүйн үйлчилгээ, мэдээллийн ажлын үр нөлөөнд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллы хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаврыг ажиглах замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаа сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь ханга замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүйн сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэглэх газар, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага байна.

#### СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч	Л. Цог
Хариуцлагатай нарийн бичгийн дарга	Б. Ганбат
Гишүүд:	Б. Бадамханд
	Ч. Дашням
	Б. Цэнддоо
	Б. Чимид
	Б. Энхбиш
Техник редактор	С. Итгэлт
Уншиж хянасан	Сав, Жаргалсайхан
	Б. Янжинлхам

Үйлдвэрт шилжүүлсэн 1997 оны 8-р сарын 2-нд  
Өрөлтөд 1997 оны 8-р сарын 16-нд. Хэвлэлтэд  
1997 оны 9-р сарын 1-нд. Хэвлэлийн хуудас 7,5  
Хэвлэсэн тоо 3820ш

Манай хаяг: Улаанбаатар-12

Төрийн ордон. Утас 322838

Төр, Засгийн Үйлчилгээ Аж Ахуйг Эрхлэх Газрын

